



# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2024 ОН

## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	4
<b>1. ХЭРЭГЛЭГЧИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....</b>	<b>7</b>
1.1 Судалгааны үндэслэл .....	7
1.2 Судалгааны зорилго, зорилт .....	7
1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ, түүврийн хэмжээ .....	8
1.4 Судалгааны практик ач холбогдол .....	10
1.5 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	11
<b>2. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭРЭГЛЭГЧДЭД ТАНИГДСАН БАЙДАЛ .....</b>	<b>19</b>
2.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн мэдлэг .....	19
2.2 Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч буй эх сурвалжууд .....	21
2.3 Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт .....	28
2.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт .....	30
2.5 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт .....	31
2.6 Хэрэглэгчдийн улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчилгээний цэгүүд ба сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээ .....	35
<b>3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ .....</b>	<b>39</b>
3.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ .....	39
3.2 Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийн үнэлгээ .....	41
3.3 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээнд тулгарч буй хүндрэл, бэрхшээл .....	42

<b>4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ .....</b>	<b>45</b>
4.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарын үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	45
4.2 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	50
4.3 Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	54
4.4 Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	57
<b>5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД .....</b>	<b>62</b>
5.1 Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн судалгааны дүгнэлт .....	62
5.2 Улсын бүртгэлийн байгууллагын танигдсан байдал болон хэрэглэгчийн үнэлгээг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд .....	64
5.3 Үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд .....	65
5.4 Үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд .....	66
5.5 Үйлчилгээг үзүүлж буй ажилтаны харилцаа, ёс зүйн талаар сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд .....	66
5.6 Үйлчилгээний байгууллагын орчин болон тохижилтыг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд .....	67
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>68</b>

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах түүвэр олонлогийн хэмжээ, нийслэл, орон нутгаар .....	9
Хүснэгт 1.2	Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах хэрэглэгчийн тоо, нийслэл, аймгуудаар .....	9
Хүснэгт 1.3	Судалгаанд оролцогчдын оролцоо .....	11
Хүснэгт 2.1	Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн байдал .....	28
Хүснэгт 2.2	Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн байдал, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	29
Хүснэгт 2.3	Улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хуулийн этгээдийн байдал .....	30
Хүснэгт 2.4	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээ .....	31
Хүснэгт 2.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн иргэд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	32
Хүснэгт 2.6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр хуулийн этгээдийн үйлчлүүлсэн үйлчилгээ .....	33
Хүснэгт 2.7	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хуулийн этгээд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	34
Хүснэгт 3.1	Үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	44
Хүснэгт 4.1	Үйлчилгээний чанарын талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	48
Хүснэгт 4.2	Үйлчилгээний хүртээмжийн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	52
Хүснэгт 4.3	Үйлчилгээний байгууллагын ажиллагсадын харилцаа, ёс зүйн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол ...	57
Хүснэгт 4.4	Үйлчилгээний байгууллагын орчин нөхцлийн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол .....	59
Хүснэгт 4.5	Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ .....	61

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1	Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд, 2024 оны байдлаар .....	12
Зураг 1.2	Судалгаанд оролцсон иргэдийн насны үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	13
Зураг 1.3	Судалгаанд оролцсон иргэдийн боловсролын түвшингийн үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	14
Зураг 1.4	Судалгаанд оролцсон иргэдийн ажил эрхлэлтийн байдлын үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	15
Зураг 1.5	Судалгаанд оролцсон байгууллагуудын ерөнхий үзүүлэлт, 2024 оны байдлаар .....	16
Зураг 1.6	Судалгаанд оролцсон хуулийн этгээдийн өмчийн хэлбэр, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	17
Зураг 1.7	Судалгаанд оролцсон хуулийн этгээдийн байгууллагын хэлбэр, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	18
Зураг 2.1	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин, 2024 оны байдлаар .....	19
Зураг 2.2	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	20
Зураг 2.3	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх хуулийн этгээдийн мэдлэгийн түвшин, 2024 оны байдлаар .....	20
Зураг 2.4	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх хуулийн этгээдийн мэдлэгийн түвшин, өмнөх судалгааны ажилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	21
Зураг 2.5	Судалгаанд хамрагдсан иргэдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, хувиар .....	22
Зураг 2.6	Судалгаанд хамрагдсан иргэдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	23
Зураг 2.7	Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, хувиар .....	24
Зураг 2.8	Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	25
Зураг 2.9	Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч	26

	буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	
Зураг 2.10	Орон нутгаас судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	27
Зураг 2.11	Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгүүд .....	35
Зураг 2.12	Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгүүд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	36
Зураг 2.13	Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн хуулийн этгээдийн үйлчилгээний цэгүүд .....	36
Зураг 2.14	Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн хуулийн этгээдийн үйлчилгээний цэгүүд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар .....	37
Зураг 2.15	Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйлчилгээнээс иргэдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ .....	38
Зураг 2.16	Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйлчилгээнээс хуулийн этгээдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ .....	38
Зураг 3.1	Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн байдал, дундаж үзүүлэлтээр, хувиар .....	39
Зураг 3.2	Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн иргэдийн ерөнхий үнэлгээ, үнэлгээний таван шатлалаар, хувиар ..	40
Зураг 3.3	Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн хуулийн этгээдийн ерөнхий үнэлгээ, үнэлгээний таван шатлалаар, хувиар .....	40
Зураг 3.4	Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийн үнэлгээ ...	41
Зураг 3.5	Иргэдийн хувьд үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хувиар .....	42
Зураг 3.6	Хуулийн этгээдийн хувьд үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хувиар .....	43
Зураг 4.1	Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар, хувиар .....	45
Зураг 4.2	Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, бүртгэлийн төрлөөр, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	46
Зураг 4.3	Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар, хувиар .....	47
Зураг 4.4	Үйлчилгээний чанарын үзүүлэлт, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	48
Зураг 4.5	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц .....	50
Зураг 4.6	Үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлт, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	51

Зураг 4.7	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц .....	53
Зураг 4.8	Үйлчилгээний ажилтны харилцааны соёл, ёс зүйн үзүүлэлт, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	54
Зураг 4.9	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудын харилцааны ёс зүй, соёлыг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц .....	57
Зураг 4.10	Байгууллагын орчин нөхцлийг үнэлсэн байдал, 2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар .....	58
Зураг 4.11	Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц .....	60

## 1. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

### 1.1 Судалгааны үндэслэл

Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд хэрэглэгчдээс үйл ажиллагааны талаар шууд хамааралд өртөөгүй бодит баримт мэдээллийг олж авах, улмаар уг мэдээлэлд үндэслэн шаардлагатай боловсруулалтыг гүйцэтгэн шинжилж, үр дүнд тулгуурлан цаашдын үйл ажиллагаанд тусган ажиллах боломжит хувилбаруудыг санал болгох, сул талаа сайжруулан шинэчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Иймд Улсын Бүтгэлийн Ерөнхий Газрын үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх хэрэглэгчийн судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төрийн захиргааны байгууллага нь жил бүр хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхэд тулгуурлан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/576 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу Улсын Бүтгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийхэд чиглэнэ.

“Гранд дата” ХХК нь Засгийн газраас гаргасан дээр дурдагдсан тушаал, журам болон судалгааны багийн зохиогчийн эрхийн гэрчилгээгээр батлагдсан тусгай арга зүйгээр энэхүү судалгааг гүйцэтгэж, Улсын Бүтгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгөөс хийсэн.

### 1.2 Судалгааны зорилго, зорилт

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэд, аж ахуй нэгжид хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас танигдалт, сэтгэл ханамж, хандлагыг тандан судалж, түүний үр дүнд зарим тоон шинжилгээг хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх боломжтой саналыг дэвшүүлэхэд оршино. Үндсэн зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:



- Бүртгэлийн үйлчилгээ болон бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх
- Бүртгэлийн үйлчилгээнд хандах хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлох
- Бүртгэлийн үйлчилгээнд хэрэглэгчийн зүгээс тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх
- Иргэд болон хуулийн этгээдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн бүртгэлийн үйлчилгээг сайжруулах, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг өгөх

### 1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ, түүврийн хэмжээ

#### А. Үнэлгээний хамрах хүрээ

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйлчилгээ болон албан тушаалтанд өгч буй иргэд, аж ахуй нэгжийн үнэлэмжийг улсын хэмжээнд судлах
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэд, аж ахуй нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийх

#### Б. Түүврийн арга зүй

- Түүвэр олонлогийн үндэслэл: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2017 оны А/302 дугаар тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн 2.4-д заасны дагуу “тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулна” гэж заасныг боломжит түүврийн дээд хязгаараар авсан.
- Түүврийн хэмжээ: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ эх олонлогийг төлөөлөх чадвараас хамааран санамсаргүй түүврийн аргаар тооцоолж, түүвэр олонлогийг дараах томъёогоор тооцоолсон. Үүнд:

$$n = \frac{z^2 P(1-P)}{e^2} * deff \quad (1)$$

$n$  - Түүврийн хэмжээ

$z$  - Тодорхой хувийн ач холбогдлын түвшин дэх  $t$  статистикийн тархалтын утга

$P$  - Түүврийн хэмжээг тодорхойлоход ашиглах түлхүүр үзүүлэлтийн эх олонлогт эзлэх хувийн жин

$e$  - Судалгаанд дэвшүүлж байгаа хүлээн зөвшөөрөх алдааны хязгаар  
 $deff$  - Түүврийн загварын нөлөөлөл

$z = 1.96$ ,  $P = 0.67$ ,  $deff = 2$ ,  $e = 0.04 * p = 0.03$  гэсэн зохих утгуудыг өгч, эх олонлог бүрээс тооцоход дараах байдалтайгаар түүвэр олонлогийн хэмжээ тооцоологдсон. Үүнд:

**Хүснэгт 1.1**

**Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах түүвэр олонлогийн хэмжээ, нийслэл, орон нутгаар**

№	Нийслэл, аймгийн нэр	Түүврийн нэгж	Эх олонлог	Түүвэр олонлог
1	Улаанбаатар хот	Хуулийн	1,100,502	332
2	Орон нутаг	этгээд, Иргэн	1,210,607	358
<b>НИЙТ</b>			<b>2,311,109</b>	<b>690</b>

Эх үүсвэр: Монгол улсын насанд хүрсэн хүн амын тоо, 2023 оны эцсийн байдлаар, Үндэсний статистикийн хороо, [www.1212.mn](http://www.1212.mn)

**Хүснэгт 1.2**

**Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах хэрэглэгчийн тоо, нийслэл, аймгуудаар**

№	Нийслэл, аймгийн нэр	Эх олонлог	Түүвэр олонлог
1	Архангай	63,185	20
2	Баян-өлгий	79,792	26
3	Баянхонгор	60,327	18
4	Булган	41,420	13
5	Говь-Алтай	38,832	11
6	Говьсүмбэр	12,345	8
7	Дархан-Уул	74,744	22
8	Дорноговь	48,935	15
9	Дорнод	57,512	17
10	Дундговь	31,538	10
11	Завхан	48,668	14
12	Орхон	75,567	21
13	Өвөрхангай	78,434	23
14	Өмнөговь	51,453	15
15	Сүхбаатар	44,952	13
16	Сэлэнгэ	73,002	18
17	Төв	62,574	17
18	Увс	57,417	15
19	Ховд	62,579	18
20	Хөвсгөл	93,635	27
21	Хэнтий	54,119	16
22	Улаанбаатар	1,100,502	332
<b>НИЙТ</b>		<b>2,311,109</b>	<b>690</b>

Эх үүсвэр: Монгол улсын хүн амын тоо, 2023 оны эцсийн байдлаар, Үндэсний статистикийн хороо, [www.1212.mn](http://www.1212.mn)

- Түүвэр цуглуулах хэлбэр:

Хэрэглэгчийн үнэлгээг Улаанбаатар хотоос цаасан асуулгын хэлбэрээр, орон нутгаас цаасан болон онлайн асуулгын хуудасны хэлбэрээр тус тус зохион байгуулсан.

- Түүвэр цуглуулах арга:

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ асуулга хуудасны судалгааны (questionnaire) аргаар зохион байгуулсан ба мэдээллийг цаасан эх сурвалжаар цуглуулсан. Асуулгын судалгааг Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 сарын 15-ны өдрийн “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж” 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан ерөнхий загвараар боловсруулав. Асуулгын судалгаанд хоёроос сонгох асуулт, олон сонголтот асуулт, Лайкерт хэмжүүрийн асуулт, ач холбогдлыг үнэлэх хэмжүүр зэрэг асуултуудыг хамруулсан. Онлайн судалгааг Google forms өргөтгөлийг ашиглан мэдээллийг цуглуулсан ба цаасан судалгааг Улсын бүртгэлийн ерөнхий газраар үйлчлүүлж буй хэрэглэгчдээс бодитоор сонгон цуглуулсан. Анхдагч судалгааг санамсаргүй түүврийн аргаар явуулж, холбогдох мэдээллийг цуглуулж, мэдээллийн боловсруулалтыг Microsoft excel, анхдагч мэдээллийг кодлох, боловсруулах, үр дүнг нэгтгэхэд SPSS 29.0 програмуудыг ашиглан тоон үр дүнг тооцоолж, холбогдох шинжилгээнүүдийг журамд заасан аргачлалаар гүйцэтгэв.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн үр дүнгээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг гаргаж, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн саналуудыг боловсруулав.

#### **1.4 Судалгааны ажлын практик ач холбогдол**

Энэхүү судалгаа нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Тухайн жилийн бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг хэрэглэгчдээр бодитоор үнэлүүлэх нь цаашид хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг төлөвлөн сайжруулахад онцгой ач холбогдолтой.
2. Судалгааны арга зүй нь Монгол Улсын Оюуны өмчийн газрын Зохиогчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажсан тул академик бичилт болон тооцоолол сайтай.

### 1.5 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд 21 аймаг болон Улаанбаатар хотын нийт 690 хэрэглэгч түүвэр олонлог хангагдан судлагдсан. Энэхүү анхдагч судалгааг Монгол улсын хэмжээнд 2024 оны 10 сарын 07-10 сарын 25-ны хооронд ажлын 14 хоногт багтаан мэдээллийг цуглуулж, орон даяар зохион байгуулсан. Судалгаанд нийт 480 иргэн, 210 хуулийн этгээд оролцсон. Судалгаанд оролцогчдыг бүс нутгийн байдлаар нь нарийвчлан харуулбал дараах бүтэцтэй байв. Үүнд:

#### Хүснэгт 1.3

#### Судалгаанд оролцогчдын оролцоо

Бүс нутаг	Иргэн		Хуулийн этгээд	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Улаанбаатар хот	240	34.8	105	15.2
Орон нутаг	240	34.8	105	15.2
<b>Нийт</b>	<b>480</b>	<b>69.6</b>	<b>210</b>	<b>30.4</b>

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ иргэн болон аж ахуй нэгж байгууллагын оролцоог тэнцвэртэй байлгах чиглэлд онцгой анхаарч ажилласан. Харин судалгаанд хамрагдсан 480 иргэний 364 нь иргэний улсын бүртгэлээс, 116 нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хамгийн сүүлд сонгон үйлчлүүлэх хугацаандаа судалгаанд хамрагджээ. Уг судалгаанд нийт 210 хуулийн этгээд хамрагдсан ба хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр 164 нь, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр 46 нь үйлчлүүлж байх хугацаандаа судалгаанд оролцсон байна.


#### Судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл:

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд өгөх хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд Монгол улсын хэмжээнд 480 иргэн хамрагдсан ба нийт судалгаанд оролцогчдын 50.0 хувь нь орон нутгаас, 50.0 хувь нь Улаанбаатар хотоос түүвэр олонлог хангагдан оролцсон.

Судалгаанд оролцогч иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтийг нэгтгэн харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

Зураг 1.1

Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд, 2024 оны байдлаар




Судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь эрэгтэй, 54.9 хувь нь эмэгтэй иргэд хамрагдав. Мөн судалгаанд оролцогчдын насны ялгаатай байдлыг авч үзвэл 42.7 хувь нь 30 хүртэлх насны, 29.8 хувь нь 31-40 насны, 18.3 хувь нь 41-50 насны, 6.9 хувь нь 51-60 насны, үлдэх 2.4 хувь нь 60-аас дээш насны хэрэглэгчид эзэлж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 57.1 хувь нь дээд боловсролтой, 34.3 хувь нь бүрэн дунд боловсролтой, 7.1 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 1.5 хувь нь бага боловсролтой байв. Харин ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 28.5 хувь нь хувийн байгууллагад, 26.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 19.6 хувь нь төрийн байгууллагад, 11.5 хувь нь оюутан, 4.0 хувь нь төрийн бус байгууллагад, 5.0 хувь нь тэтгэвэрт, үлдэх хэсэг нь олон улсын байгууллага болон эрхэлсэн ажилгүй иргэд судалгаанд хамрагдсан байна.

Харин судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн үзүүлэлтийг өмнөх жилүүдийн мөн үетэй зэрэгцүүлэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 1.2

Судалгаанд оролцсон иргэдийн насны үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар




Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны хүн ам зүйн үзүүлэлтийг өмнөх жилийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд насны ялгаатай байдал нь өмнөх жилийн судалгаанаас 30 хүртэлх насны хэрэглэгчид 7.5 пунктээр илүү хамрагдсан бол 31-40 хүртэлх насны хэрэглэгчид 0.3 пунктээр, 41-50 насны хэрэглэгчид 2.6 пункт, 51-60 насны хэрэглэгчид 3.7 пунктээр тус тус бага хамрагдсан үзүүлэлттэй байна. Судалгааны үр дүнгийн суурь оныг 2020 он гэж үзвэл 30 хүртэлх насны хэрэглэгчид 6.6 пунктээр, бол 31-40 хүртэлх насны хэрэглэгчид 1.2 пунктээр илүү хамрагдсан бол 41-50 насны хэрэглэгчид 1.3 пунктээр, 51-60 насны хэрэглэгчид 5.7 пунктээр, 60-аас дээш насны иргэд 3.0 пунктээр тус тус судалгаанд бага хамрагджээ.

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийг хүйсийн ялгаатай байдлаар нь авч үзвэл өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэн үзэхэд 2024 оны судалгаанд эмэгтэй хэрэглэгчийн эзлэх жингийн өөрчлөлт 6.0 пунктээр нэмэгдсэн дүр зурагтай байна.

Боловсролын түвшин нь өмнөх жилийн судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд дээд боловсролтой иргэд 3.4 пунктээр, бага боловсролтой иргэд 0.2 пунктээр тус тус илүү оролцсон бол бүрэн дунд боловсролтой иргэд 1.0 пунктээр, бүрэн бус дунд боловсролтой хэсэг нь 2.1 пунктээр бага хамрагдсан үзүүлэлттэй байна.

Зураг 1.3

Судалгаанд оролцсон иргэдийн боловсролын түвшингийн үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар




Судалгааны үр дүнгийн суурь оныг 2020 он гэж үзвэл дээд боловсролтой иргэд нь судалгаанд 1.6 пункт, бүрэн бус дунд боловсролтой иргэд 0.6 пунктээр бага оролцож, харин бүрэн дунд боловсролтой иргэд 1.1 пункт, бага боловсролтой иргэд 1.1 пунктээр илүү судалгаанд оролцжээ.

Судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэлтийн түвшинг өмнөх оны мөн үзүүлэлттэй зэрэгцүүлэн авч үзэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгч 3.6 пункт, оюутан 2.4 пункт, тэтгэвэрт 0.4 пункт, төрийн байгууллагад ажиллагсад 3.3 пунктээр илүү хамрагдсан бол эрхэлсэн ажилгүй иргэд 1.0 пункт, хувийн байгууллагад ажиллагсад 3.2 пункт, төрийн бус 2.1 пункт, байгууллагад ажиллагсад төрийн бус байгууллагад ажиллагсад 1.0 пункт, олон улсын байгууллагад ажиллагсад 3.3 пунктээр тус тус судалгаанд бага оролцсон нь зэрэгцүүлсэн үр дүнгээс тодорхой харагдаж байна.

Судалгааны үр дүнгийн суурь оныг 2020 он гэж үзвэл хувийн байгууллагад ажиллагсад 1.8 пункт, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1.2 пункт, оюутан 5.8 пунктээр судалгаанд илүү оролцсон бол эрхэлсэн ажилгүй иргэд 6.5 пункт, тэтгэврийн насны иргэд 3.9 пункт, төрийн бус байгууллагын ажиллагсад 2.4 пункт, төрийн байгууллагад ажиллагсад 0.3 пунктээр тус тус бага оролцжээ.

Зураг 1.4

Судалгаанд оролцсон иргэдийн ажил эрхлэлтийн байдлын үзүүлэлт, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар



Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд өгөх хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдсан нийт иргэдийн хүн ам зүйн ялгаатай байдлаарх үр дүнг дээрх байдлаар дэлгэрүүлэв.




**Судалгаанд оролцсон байгууллагын мэдээлэл:**

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд өгөх хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд Монгол улсын хэмжээнд 210 байгууллага хамрагдсан ба нийт судалгаанд оролцогчдын 50.0 хувь нь орон нутгаас, 50.0 хувь нь Улаанбаатар хотоос түүвэр олонлог хангагдан оролцсон.

Судалгаанд оролцогч хуулийн этгээдийн ерөнхий үзүүлэлтийг нэгтгэн харуулбал доорх байдалтай байна. Үүнд:

**Зураг 1.5**

**Судалгаанд оролцсон байгууллагуудын ерөнхий үзүүлэлтүүд, 2024 оны байдлаар**




Судалгаанд оролцогч байгууллагуудыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 61.6 хувь нь хувийн өмчийн байгууллага, 19.5 хувь нь төрийн өмчийн байгууллага, 18.9 хувь нь орон нутгийн өмчийн байгууллагууд оролцсон. Судалгаанд оролцсон байгууллагуудын хэлбэрийг авч үзэхэд 63.8 хувь нь ХХК, ХК, 15.8 хувь нь төсвийн

байгууллага, 17.2 хувь нь төрийн бус байгууллага, үлдэх 3.3 хувь нь хоршоо зэрэг хуулийн этгээд оролцжээ. Тухайн хуулийн этгээдүүдийн ажилчдын тоог тодруулахад 54.1 хувь нь 10-аас бага, 25.9 хувь нь 11-30, 11.9 хувь нь 31-50, 5.9 хувь нь 51-70, 2.2 хувь нь 71-ээс дээш тооны ажиллагсадтай байв. УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг өмчийн болон хэлбэрийн ялгаатай байдлаас үл хамааран бүхий л байгууллагууд үйлчлүүлдэг болох нь дээрх үр дүнд тодорхой байна.

Харин судалгаанд оролцсон хуулийн этгээдүүдийн статистик үзүүлэлтийг өмнөх жилүүдийн мөн үетэй зэрэгцүүлэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:


Зураг 1.6

**Судалгаанд оролцсон хуулийн этгээдийн өмчийн хэлбэр, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**



Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2024 оны үйл ажиллагаанд өгөх хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн өмчийн хэлбэрийн үзүүлэлтийг өмнөх жилийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд төрийн өмчийн байгууллага нь 5.2 пункт, орон нутгийн байгууллага 17.5 пунктээр илүү хамрагдаж, харин хувийн өмчийнн байгууллага нь 22.8 пунктээр судалгаанд бага хамрагдсан байна. Судалгааны үр дүнгийн суурь оныг 2020 он гэж үзвэл судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн өмчийн хэлбэрээр зэрэгцүүлэн үзэхэд төрийн өмчийн байгууллага нь 12.7 пункт, орон нутгийн байгууллага 16.9 пунктээр илүү хамрагдаж, харин хувийн өмчийнн байгууллага нь 29.4 пунктээр судалгаанд бага хамрагдсан байна.

**Судалгаанд оролцсон хуулийн этгээдийн байгууллагын хэлбэр,  
өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**



Байгууллагын хэлбэр нь өмнөх жилийн судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд ХК, ХХК нь 12.7 пункт, хоршоо нь 1.5 пунктээр тус тус энэ жилийн судалгаанд бага хамрагдаж, харин төсвийн байгууллага нь 10.4 пункт, төрийн бус байгууллага нь 3.9 пунктээр тус тус судалгаанд илүү хамрагдсан байна. Судалгааны үр дүнгийн суурь оныг 2020 он гэж үзвэл судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хэлбэрийг зэрэгцүүлэн үзэхэд ХК, ХХК нь 7.5 пункт, төрийн бус байгууллага нь 2.4 пунктээр энэ жилийн судалгаанд бага хамрагдаж, харин төсвийн байгууллага нь 8.9 пункт, хоршоо нь 1.1 пунктээр тус судалгаанд илүү хамрагдсан байна.

Уг судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээнд хандах хэрэглэгчийн үнэлгээг гүйцэтгэхэд ашигласан арга зүй, зорилго, зорилт, түүвэрлэлтийн арга зүй, судалгааны давуу тал болон судалгаанд хамрагдсан оролцогчдын ерөнхий мэдээллийг дэлгэрэнгүй харуулав.

Энэхүү судалгааны тайлангийн агуулгын дагуу хоёрдугаар бүлэгтээ Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээ нь зах зээлд хэрхэн танигдсан байдлыг дэлгэрэнгүй тайлагнах ба өмнөх жилүүдийн мөн үетэй харьцуулсан үр дүнг нарийвчлан тайлбарлах болно.


## 2. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭРЭГЛЭГЧДЭД ТАНИГДСАН БАЙДАЛ

### 2.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн мэдлэг

Улсын бүртгэлийн байгууллагын удирдан зохион байгуулж явуулдаг бүртгэлийн үйл ажиллагааны тухай хэрхэн мэддэг байдлыг судалгаанд хамрагдсан нийт иргэд болон хуулийн этгээдээс тодруулахад дараах үр дүн гарсан. Үүнд:

Зураг 2.1

#### Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин, 2024 оны байдлаар




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг 31.9 хувь нь мэддэг, 34.4 хувь нь дундаас дээш түвшний мэдлэгтэй, 5.4 хувь нь маш сайн мэддэг гэж хариулсан. Үүнээс үзэхэд

нийт хэрэглэгчдийн 70 гаруй хувь нь улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэгтэй байна. Харин 21.6 хувь нь бага зэрэг мэдлэгтэй, 7.1 хувь нь үйл ажиллагааны талаар огт мэддэггүй гэж үнэлснээс үзэхэд иргэдэд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх шинэ мэдээ, мэдээллийг хүргэхэд анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэгийн түвшинг өмнөх судалгааны жилийн мөн үетэй зэрэгцүүлэн харуулсныг зураг 2.2-д харуулав. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэний мэдлэгийн түвшинг өмнөх жилийн судалгаанд хамрагдсан иргэдийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд маш сайн мэдлэгтэй иргэд 0.9 пункт, дунд түвшинд мэддэг иргэд 1.3 пунктээр өссөн бол мэдэхгүй иргэд 4.9 пункт, бага зэрэг мэддэг иргэд 5.4 пунктээр тус тус буурсан байна. Улсын бүртгэлийн байгууллагын талаарх иргэдийн мэдлэгийн түвшинг судалгааны үр дүнгийн суурь онтой харьцуулахад маш бага мэдлэгтэй хэрэглэгчдийн тоо 9.7 пунктээр буурсан байна.


Зураг 2.2

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар



Зураг 2.3


Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх хуулийн этгээдийн мэдлэгийн түвшин, 2024 оны байдлаар



Судалгаанд хамрагдсан нийт хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг 15.1 хувь нь маш сайн мэддэг, 34.6 хувь нь мэддэг, 25.4 хувь нь дунд зэрэг мэддэг, 15.7 хувь нь бага зэрэг мэддэг гэж хариулсан. Үүнээс үзэхэд

нийт хуулийн этгээдийн 80 орчим хувь нь улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэгтэй байна. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хуулийн этгээдийн мэдлэг нь иргэдийн мэдлэгтэй харьцуулахад өндөр байна.

**Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх  
хуулийн этгээдийн мэдлэгийн түвшин, өмнөх судалгааны жилүүдийн  
зэрэгцүүлэлт, хувиар**



Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх хуулийн этгээдийн мэдлэгийн түвшинг өмнөх жилийн судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн үзүүлэлттэй зэрэгцүүлэн үзэхэд улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар огт мэдлэггүй хуулийн этгээд нь 0.7 пункт, бага зэрэг мэддэг хуулийн этгээд 4.6 пунктээр тус тус өссөн байна. Харин улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаарх хуулийн этгээдийн мэдлэгийн түвшинг суурь онтой харьцуулахад маш сайн мэдлэгтэй хуулийн этгээд 1.0 пунктээр, мэддэг хуулийн этгээд 3.4 пунктээр, дунд зэрэг мэдлэгтэй хуулийн этгээдүүд 3.9 пунктээр тус тус буурсан нь үйл ажиллагаагаа хуулийн этгээдүүдэд өргөн хүрээнд таниулах шаардлагатайг илтгэж байна.


## **2.2 Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг авч буй эх сурвалжууд**

Судалгааны тайлангийн энэ хэсэгт судалгаанд хамрагдсан иргэд болон хуулийн этгээдээс улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас олж авдаг болохыг тодруулсан.

Улсын бүртгэлийн байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг ямар эх сурвалжаас олж авдаг эсэхийг судалгаанд хамрагдсан иргэдээс тодруулахад доорх үр дүн гарав.

Зураг 2.5

**Судалгаанд хамрагдсан иргэдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, хувиар**




Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 22.8 хувь нь [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хаягнаас, 20.8 хувь нь нийгмийн сүлжээ (Facebook, Twitter), 18.8 хувь нь бусад мэдээллийн сайтаас, 14.1 хувь нь байгууллагын лавлах утаснаас, 11.5 хувь нь телевиз, радио, FM-ээс, 7.7 хувь нь мэдээллийн самбараас, 3.6 хувь нь сонин сэтгүүлээс, 0.7 хувь нь брошур танилцуулгаас мэдээллийг авдаг гэсэн үр дүн гарчээ.

Үүнээс үзэхэд хэрэглэгчид нь мэдээллийн эх үүсвэрийг цахим хэлбэрээр, албан ёсны эх сурвалжаас авах хандлага нь орчин цагаа дагаад нэмэгдсэн нь харагдаж байна. Харин өмнөх жилийн судалгааны үр дүнтэй энэ жилийн судалгааны үр дүнг зэрэгцүүлэн харвал дараах байдалтай байна.

Зураг 2.6

Судалгаанд хамрагдсан иргэдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар



Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудаснаас авдаг нь 2.5 пункт, байгууллагын лавлах утаснаас 1.8 пункт, мэдээллийн сайтаас 4.6 пунктээр тус тус өссөн байна. Харин мэдээллийн самбараас 0.4 пункт, брошур танилцуулгаас 2.3 пункт, нийгмийн




сүлжээнээс (Facebook, Twitter) 4.3 пункт, телевиз, радио, FM-ээс мэдээллийг авч буй байдал нь 1.0 пунктээр өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад бага үр дүн гарчээ.

Улсын бүртгэлийн байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг ямар эх сурвалжаас олж авдаг эсэхийг судалгаанд хамрагдсан хуулийн этгээдээс тодруулахад доорх үр дүн гарав.

Зураг 2.7


Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, хувиар



Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 24.7 хувь нь [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хаягнаас, 21.5 хувь нь байгууллагын лавлах утаснаас, мэдээллийн сайтнаас 16.3 пункт, сонин сэтгүүлээс 9.0 пункт, мэдээллийн самбараас 8.3 пункт, телевиз, радио, FM-ээс 8.3 пункт, мэдээллийн самбараас 8.0 пункт, 3.8 хувь нь нийгмийн сүлжээнээс мэдээллийг авдаг гэсэн үр дүн гарчээ. Үүнээс үзэхэд хуулийн этгээд ч иргэдтэй мөн адилаар мэдээллийн эх үүсвэрийг цахим хэлбэрээр албан ёсны эх сурвалжаас авах хандлага нь орчин цагаа дагаад нэмэгдсэн нь харагдаж байна. Харин өмнөх жилийн судалгааны үр дүнтэй энэ жилийн судалгааны үр дүнг зэрэгцүүлэн харуулсан үр дүнг зураг 2.8-д харуулав.

Зураг 2.8

Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар




Судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын лавлах утаснаас авдаг нь 9.7 пункт, брошур танилцуулгаас 6.9 пункт, сонин сэтгүүлээс 4.3 пункт, мэдээллийн сайтуудаас авдаг нь 1.8 пунктээр тус тус өмнөх жилээс өссөн бол [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хуудаснаас авдаг нь 2.6 пункт, мэдээллийн самбараас 0.8 пункт, нийгмийн сүлжээнээс 20.1 пунктээр өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад бага дүнтэй гарсан байна. Харин нийгмийн сүлжээнээс (Facebook, Twitter) 10.8 пункт,

телевиз, радио, FM-ээс мэдээллийг авч буй байдал нь 7.2 пунктээр өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад бага байна.

Судалгаанд хамрагдсан иргэд болон хуулийн этгээдээс улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ямар эх сурвалжаас олж авдаг болохыг Улаанбаатар хот болон орон нутгийн хэрэглэгчдийн ялгаатай байдлаар харуулахад доорх үр дүн гарав.

Зураг 2.9

**Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**




Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 25.4 хувь нь

нийгмийн сүлжээ (Facebook, Twitter), 23.1 хувь нь [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хаягнаас, 19.3 хувь нь байгууллагын лавлах утаснаас, 16.2 хувь нь мэдээллийн бусад сайтаас, 6.8 хувь нь телевиз, радио, FM-ээс, 1.2 хувь нь сонин сэтгүүлээс, 2.3 хувь нь брошур танилцуулгаас мэдээллийг авдаг гэсэн үр дүн гарчээ. Мэдээллийг хүлээн авдаг эх сурвалжийг өмнө жилийн мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотын хэрэглэгчдийн хувьд [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хаяг, байгууллагын лавлах утас, бусад мэдээллийн сайтуудаас авах мэдээллүүд өссөн дүр зурагтай харагдаж байна.

Зураг 2.10

**Орон нутгаас судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч буй эх сурвалж, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**



Орон нутгаас судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 33.7 хувь нь нийгмийн сүлжээ (Facebook, Twitter), 17.4 хувь нь [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим хаягнаас, 18.9 хувь нь байгууллагын лавлах утаснаас, 11.4 хувь нь мэдээллийн бусад сайтаас 9.9 хувь нь телевиз, радио, FM-ээс, 4.8 хувь нь брошур танилцуулгаас, 2.3 хувь нь сонин сэтгүүлээс, мэдээллийг авдаг гэсэн үр дүн гарчээ. Мэдээллийг хүлээн авдаг эх сурвалжийг өмнө жилийн мөн үетэй харьцуулахад орон нутгийн хэрэглэгчдийн хувьд байгууллагын лавлах утас, брошур танилцуулга, телевиз, радиогоос авах мэдээллүүд өссөн дүр зурагтай харагдаж байна.

Үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж буй орчин цагийн хэрэглэгчдийн мэдээллийг авч буй суваг нь илүү сошиал медиа тал руугаа хөгжиж буй тул Улаанбаатар хот болон орон нутгийн хэрэглэгч гэж ялгаа байхгүйгээр ухаалаг төхөөрөмжид суурилсан эх сурвалжаар үйл ажиллагааныхаа мэдээллийг өгөх нь ач холбогдолтой.

### 2.3 Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт

Энэхүү судалгаанд нийт 480 иргэн оролцсон ба иргэний улсын бүртгэлийн үйлчилгээгээр давхардсан тоогоор 522, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг давхардсан тоогоор 218 иргэн авсан байна.

#### Хүснэгт 2.1

##### Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн байдал

Иргэний улсын бүртгэл	Хувь
Төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, нас барсны бүртгэл	20.4%
Үрчлэлт, овог нэр өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний бүртгэл	17.9%
Иргэний үнэмлэх, гадаад паспорт	38.5%
Лавлагаа авах	23.2%

Судалгаа авах хугацаанд судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнээс иргэний үнэмлэх, гадаад паспорт авах үйлчилгээнд 38.5 хувь, лавлагаа авах үйлчилгээнд 23.2 хувь, төрсний гэрчилгээ, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, нас барсны бүртгэлд бүртгүүлэх үйлчилгээг 20.4 хувь, үрчлэлт, овог нэр өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 17.9 хувь нь тус тус үйлчлүүлсэн байна. Уг үр дүнг өмнөх оны судалгааны үр дүнг зэрэгцүүлж хүснэгт 2.2-д харуулав.

**Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн байдал,  
өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**

Иргэний улсын бүртгэл	2020	2021	2022	2023	2024	Өмнө жилийн өөрчлөлт	Суурь оны өөрчлөлт
Улсын бүртгэлд бүртгүүлэх (төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт шинээр авах)	45.3%	41.7%	40.2%	54.7%	20.4%	-34.3%	24.9%
Үрчлэлт, гэрлэлт, нас баралтын бүртгэл	3.5%	8.6%	13.2%	9.1%	17.9%	8.8%	-14.4%
Улсын бүртгэлд өөрчлөлт хийх, сунгуулах, бүртгэлээс хасалт хийлгэх	18.6%	15.3%	11.1%	15.6%	38.5%	-22.7%	-19.9%
Лавлагаа авах	32.6%	34.4%	35.5%	20.6%	23.2%	-2.6%	9.4%

Судалгаанд хамрагдсан нийт иргэд нь өмнөх жилийн судалгаанд хамрагдсан иргэдтэй харьцуулахад үрчлэлт, гэрлэлт, нас баралтын бүртгэлийн үйлчилгээнд хамрагдсан иргэд 8.8 пунктээр илүү хамрагдсан бол иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх буюу төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт шинээр авах үйлчилгээнд 34.3 пунктээр, улсын бүртгэлд өөрчлөлт хийх, сунгуулах, бүртгэлээс хасалт хийлгэх үйлчилгээнд 22.7 пунктээр, лавлагаа авах үйлчилгээнд 2.6 пунктээр тус тус бага хамрагджээ.

Иргэний бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн хэрэглэгчийн байдлыг судалгааны суурь онтой харьцуулан өөрчлөлтийг гаргахад иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх буюу төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, гадаад паспорт шинээр авах үйлчилгээ нь 24.9 пунктээр, лавлагаа авах үйлчилгээ нь 9.4 пунктээр нэмэгдсэн бол улсын бүртгэлд өөрчлөлт хийх, сунгуулах, бүртгэлээс хасалт хийлгэх үйлчилгээ нь 19.9 пунктээр, үрчлэлт, гэрлэлт, нас баралтын бүртгэл нь 14.4 пунктээр тус тус бага хамрагджээ.

**2.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт**

Энэхүү судалгаанд нийт 210 хуулийн этгээд оролцсон ба хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр давхардсан тоогоор 224, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг давхардсан тоогоор 117 аж ахуй нэгж байгууллагууд үйлчлүүлсэн байна.

**Хүснэгт 2.3**

**Улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хуулийн этгээдийн байдал**

Хуулийн этгээдийн улсын бүртгэл	Хувь
Хуулийн этгээд шинээр байгуулагдсан бүртгэл	27.0%
Хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бүртгэл	12.6%
Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон бүртгэл	16.0%
Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон/ татан буугдсан бүртгэл	12.6%
Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын бүртгэл	7.8%
Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл	6.1%
Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах бүртгэл	6.8%
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа, хуулбар өгөх	4.1%
Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй	6.8%

Судалгаанд оролцогчдын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнээс хуулийн этгээд шинээр байгуулагдсан бүртгэлд 27.0 хувь, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бүртгэлд 12.6 хувь, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон бүртгэлд 16.0 хувь, хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон, татан буугдсан бүртгэлд 12.6 хувь, хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд 7.8 хувь, хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэлд 6.1 хувь, хуулийн этгээдийн нэр баталгаажуулах бүртгэлд 6.8 хувь, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа, хуулбар өгөх үйлчилгээнд 4.1 хувь, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй нь 6.8 хувь нь тус тус хамрагдсан байна. Уг судалгааны асуулга нь шинэ хуулийн заалттай холбоотойгоор энэ оны судалгаанд шинэчлэн найруулагдсан тул өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлсэн тооцоолол хийгдээгүй болно.

**2.5 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний танигдсан байдал ба өмнөх жилийн харьцуулалт**

Судалгаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр давхардсан тоогоор 366 иргэн, 71 аж ахуй нэгж байгууллага үйлчлүүлсэн байна.

**Хүснэгт 2.4**

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээ**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл	Хувь
Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	18.8%
Газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	4.9%
Өмчлөгч өөрчлөх (худалдах худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ)	18.6%
Үнэгүй хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт, бүртгэл	9.2%
Барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох	6.3%
Бусад бүртгэл – бүртгэлд өөрчлөлт оруулах, урьдчилсан тэмдэглэл хийх, лавлагаа, мэдээлэл авах, хаяг талбай өөрчлөх	5.3%
Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгалт, цуцлалт, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа (гэрчилгээ хайлт)	36.9%

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнээс 18.8 хувь нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээг, 4.9 хувь нь газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээг, 18.6 хувь нь өмчлөгч өөрчлөх (худалдах худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ) үйлчилгээг, 6.3 хувь нь барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох үйлчилгээ, 36.9 хувь нь хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээг, 9.2 хувь нь үнэгүй хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт, бүртгэлийн үйлчилгээг, 5.3 хувь нь бусад бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн байна. Уг үр дүнг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлснийг хүснэгт 2.5-д харуулав.



Хүснэгт 2.5

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн иргэд,  
 өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар

Иргэний улсын бүртгэл	2020	2021	2022	2023	2024	Өмнө жилийн өөрчлөлт	Суурь оны өөрчлөлт
Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	41.6%	32.9%	23.4%	25.6%	18.8%	-6.8%	22.8%
Газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	22.1%	17.6%	14.3%	11.9%	4.9%	-7.0%	17.2%
Өмчлөгч өөрчлөх (худалдах, худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ)	22.1%	20.2%	20.3%	18.1%	18.6%	0.5%	3.5%
Үнэгүй хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт, бүртгэл	3.5%	8.0%	8.4%	5.1%	9.2%	4.1%	-5.7%
Барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох	3.5%	9.9%	15.6%	17.2%	6.3%	-10.9%	-2.8%
Бусад бүртгэл – бүртгэлд өөрчлөлт оруулах, урьдчилсан тэмдэглэл хийх, лавлагаа, мэдээлэл авах, хаяг талбай өөрчлөх	3.5%	8.5%	6.8%	7.8%	5.3%	-2.5%	-1.8%
Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгалт, цуцлалт, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа (гэрчилгээ хайлт)	3.5%	4.9%	11.2%	10.6%	36.9%	26.3%	-33.4%

Өмнөх оны судалгааны үр дүнтэй энэ жилийн үр дүнг харьцуулахад өмчлөгч өөрчлөх (худалдах, худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ) бүртгэл 0.5 пунктээр, үнэгүй хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт, бүртгэл 4.1 пунктээр, хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээ 26.3 пунктээр тус тус өссөн. Харин үлд хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл

6.8 пунктээр, газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээг 7.0 пунктээр, барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох бүртгэл 10.9 пунктээр, бусад бүртгэлээр үйлчлүүлсэн нь 2.5 пунктээр тус тус буурчээ.

Судалгаанд хамрагдсан иргэд нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн байдлыг судалгааны суурь онтой харьцуулан өөрчлөлтийг гаргахад үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ нь 22.8 пунктээр, газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ нь 17.2 пунктээр, өмчлөгч өөрчлөх (худалдах, худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ) бүртгэлд 3.5 пунктээр тус тус өссөн байна. Харин үнэгүй хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийн анхны баталгаажуулалт хийх бүртгэлийн үйлчилгээ 5.7 пунктээр, барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох үйлчилгээ 2.8 пунктээр, хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээ 7.1 пунктээр газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ 33.4 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 2.6**

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр  
хуулийн этгээдүүдийн үйлчлүүлсэн үйлчилгээ**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл	Хувь
Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	15.2%
Газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	3.7%
Өмчлөгч өөрчлөх (худалдан, худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ)	12.2%
Барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох	13.0%
Бусад бүртгэл – Бүртгэлд өөрчлөлт оруулах, урьдчилсан тэмдэглэл хийх, лавлагаа, мэдээлэл авах	18.9%
Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгалт, цуцлалт, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа (гэрчилгээ хайлт)	11.1%

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнээс 15.2 хувь нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээг, 3.7 хувь нь газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээг, 12.2 хувь нь өмчлөгч өөрчлөх (худалдах худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ) үйлчилгээг, 13.0 хувь нь барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох үйлчилгээ, 11.1 хувь нь хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл,

барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээг, 18.9 хувь нь бусад бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн байна. Уг үр дүнг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлснийг хүснэгт 2.7-д харуулав.

**Хүснэгт 2.7**

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн хуулийн этгээд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**

Эд хөрөнгийн улсын бүртгэл	2020	2021	2022	2023	2024	Өмнө жилийн өөрчлөлт	Суурь оны өөрчлөлт
Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл	25.0%	21.5%	23.3%	24.0%	15.2%	8.8%	9.8%
Газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл	14.0%	13.1%	12.8%	17.2%	3.7%	13.5%	10.3%
Өмчлөгч өөрчлөх (худалдан, худалдан авах, бэлэглэх, арилжих, бусад гэрээ)	21.0%	21.5%	20.4%	20.1%	12.2%	7.9%	8.8%
Барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох	11.0%	17.0%	14.6%	10.3%	13.0%	-2.7%	-2.0%
Бусад бүртгэл – Бүртгэлд өөрчлөлт оруулах, урьдчилсан тэмдэглэл хийх, лавлагаа, мэдээлэл авах	7.0%	10.8%	12.4%	12.4%	18.9%	-6.5%	-11.9%
Хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгалт, цуцлалт, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа (гэрчилгээ хайлт)	21.0%	17.1%	16.5%	15.3%	11.1%	4.2%	9.9%

Өмнөх оны судалгааны үр дүнтэй энэ жилийн үр дүнг харьцуулахад үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ 8.8 пунктээр, газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ 13.5 пунктээр, өмчлөгч өөрчлөх бүртгэлийн үйлчилгээ 7.9 пунктээр, хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээ 4.2

пунктээр тус тус өссөн. Харин барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох үйлчилгээ 2.7 пунктээр, бусад бүртгэлийн үйлчилгээ 6.5 пунктээр тус тус бага үйлчлүүлсэн байна.


Судалгаанд хамрагдсан хуулийн этгээд нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн байдлыг судалгааны суурь онтой харьцуулан өөрчлөлтийг гаргахад үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ 9.8 пунктээр, газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэлийн үйлчилгээ 10.3 пунктээр, өмчлөгч өөрчлөх бүртгэлийн үйлчилгээ 8.8 пунктээр, хөдлөх хөрөнгийн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, сунгах, цуцлах, өмнө үүссэн барьцааны мэдэгдэл, барьцаалуулагчийн тайлбар, өөрчлөлт, лавлагаа авах үйлчилгээ 9.9 пунктээр тус тус өссөн. Харин барьцааны гэрээ бүртгэх, дуусгавар болгох үйлчилгээ 2.0 пунктээр, бусад бүртгэлийн үйлчилгээ 11.9 пунктээр тус тус бага оролцоотойгоор үйлчлүүлж судалгаанд оролцжээ.

**2.6 Хэрэглэгчдийн улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчилгээний цэгүүд ба сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээ**

Судалгаанд хамрагдсан нийт 690 иргэн, хуулийн этгээд нь давхардсан тоогоор 1098 байрлалаас бүртгэлийн үйлчилгээг 2024 онд авсан байна.

**Зураг 2.11**

**Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгүүд**




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 39.7 хувь нь нэг цэгийн үйлчилгээгээр, 14.2 хувь нь улсын бүртгэгчээр, 22.2 хувь нь e-mongolia цахим порталаас, 23.9 хувь нь улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машинаас /киоск/ улсын бүртгэлийн үйлчилгээг авсан байна.

2024 оны Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхэд нэг цэгийн үйлчилгээний талаарх асуулга оруулаагүй тул харьцуулалтыг үлдэх хариултуудаар зэрэгцүүлэв. Судалгаанд хамрагдсан иргэдийн

хувьд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад улсын бүртгэгчээр үйлчлүүлсэн хэрэглэгчид 19.8 пунктээр, E-Mongolia цахим порталаар үйлчлүүлэгсэд 12.4 пунктээр, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний цахим машинаас /киоск/ үйлчилгээ авч буй нь 6.3 пунктээр тус тус нэмэгдсэн.

Зураг 2.12


**Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгүүд, өмнөх судалгааны жилүүдийн зэрэгцүүлэлт, хувиар**



Иргэдийн улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчилгээний цэгийг суурь оны үзүүлэлттэй харьцуулахад Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний цахим машинаас /киоск/ авах үйлчилгээ болон нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлсэн байдал өссөн үзүүлэлттэй байна. Үүнтэй холбоотойгоор үйлчилгээний цэгүүдийн ачаалал тархмал болж иргэд харьцангуй онлайнаар үйлчилгээг авах байдал нь эрчимжсэн.

Зураг 2.13

**Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн хуулийн этгээдийн үйлчилгээний цэгүүд**



Судалгаанд хамрагдсан нийт хуулийн этгээдийн 41.1 хувь нь нэг цэгийн үйлчилгээнээс, 13.5 хувь нь улсын бүртгэгчээс, 23.1 хувь нь E-Mongolia цахим порталаас, 11.1 хувь нь улсын бүртгэлийн


үйлчилгээний цахим машинаас /киоск/, 10.9 хувь нь E-Business цахим порталаас улсын бүртгэлийн үйлчилгээг авсан байна.

2024 онд Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг авсан хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үйлчилгээний цэгийг суурь оны үзүүлэлттэй харьцуулахад E-Mongolia цахим портал болон E-Business цахим порталын хэрэглээ огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор үйлчилгээний цэгүүдийн ачаалал тархмал болж хуулийн этгээдүүд ч мөн адил үйлчилгээг онлайнаар авах байдал нь эрчимжсэн.

Улсын бүртгэлийн байгууллагаас 2024 онд хэрэгжүүлсэн үйлчилгээ нь хэр сэтгэл ханамжид нийцэж буйг иргэдээс тодруулсныг доорх байдлаар харуулав.

Зураг 2.14

**Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйлчилгээнээс иргэдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ**




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын 2024 онд сайжруулан нэвтрүүлсэн E-Mongolia цахим порталд 31.4 хувь, нэг цэгийн үйлчилгээнд 13.3 хувь, Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин, киоск үйлчилгээнд 13.2 хувь, гэрэгэ киоск үйлчилгээнд 12.3 хувь, [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим лавлагаа, үйлчилгээнд 8.2 хувь, харьяалал харгалзахгүй үйлчилгээнд 9.5 хувь, цахим гадаад паспортын үйлчилгээнд 4.7 хувь нь сэтгэл ханамж өндөр байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн үйлчилгээний цэгийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлэгсэд 8.4 пунктээр, E-Mongolia цахим портал,

цахим гадаад паспорт, зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчлүүлэх үйлчилгээ, 24/7 үйлчилгээ зэрэгт хандах иргэдийн хандлага эерэг байна.

Зураг 2.15

**Улсын бүртгэлийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйлчилгээнээс хуулийн этгээдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ**



Судалгаанд хамрагдсан нийт хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын 2024 онд сайжруулан нэвтрүүлсэн E-Mongolia цахим порталд 30.8 хувь, [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn) цахим лавлагаа, үйлчилгээнд 20.3 хувь, нэг цэгийн үйлчилгээнд 13.4 хувь, гэрэгэ киоск үйлчилгээнд 14.5 хувь, Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин, киоск үйлчилгээнд 14.1 хувь, бүртгэх хугацааг богиносгосон үйлчилгээ 3.3 хувийг эзлэх хуулийн этгээдүүд сэтгэл ханамж өндөр байна.

Иймд бүртгэлийн байгууллагын үйлчилгээг илүү цахимжуулж, хэрэглэгчдийг чирэгдэлгүйгээр зайнаас үйлчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, цаг хугацааг хэмнэх, албан ёсны сувгаас мэдээлэл авах зэрэгт анхаарах нь үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх эх үүсвэр болох талтай.


### 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

#### 3.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний талаарх хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын хувьд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчдээс үндсэн чиг үүргийн дагуух үйлчилгээг үнэлүүлэхэд дараах үр дүн гарсан. Үүнд:

Зураг 3.1

#### Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн байдал, дундаж үзүүлэлтээр, хувиар




Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг судалгаанд хамрагдсан нийт иргэд, хуулийн этгээдийн үнэлгээний дунджаар авч үзэхэд улсын бүртгэлээс лавлагаа тодорхойлолт авах үйлчилгээний үнэлгээ 4.15, улсын бүртгэлийн өөрчлөлтийн бүртгэлийн үйлчилгээ 4.07, улсын бүртгэлээс хасалт хийх үйлчилгээний үнэлгээ 3.84, улсын бүртгэлд шинээр бүртгэх үйлчилгээ 3.75, тамга тэмдгийн хяналтын хуудас авах үйлчилгээ 3.36 гэж үнэлсэн. Энэхүү үнэлгээг өмнөх жилийн үр дүнтэй зэрэгцүүлэн үзвэл дараах байдалтай байна.

Иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг үндсэн чиг үүргийнх нь дагуу үнэлсэн байдлыг авч үзэхэд лавлагаа, тодорхойлолт авах үйлчилгээ болон улсын бүртгэлийн өөрчлөлтийн үйлчилгээд хэрэглэгчдийн 70-аас дээш хувь нь дундаас дээш гэж үнэлж байна.



Зураг 3.2


Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн иргэдийн ерөнхий үнэлгээ, үнэлгээний таван шатлалаар, хувиар



Харин улсын бүртгэлд өөрчлөлт хийх болон улсын бүртгэлээс хасалт хийх зэрэг үйлчилгээнүүд нь 70 гаруй орчим хувь нь дундаас дээш гэж үнэлжээ.

Зураг 3.3

Улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг үнэлсэн хуулийн этгээдийн ерөнхий үнэлгээ, үнэлгээний таван шатлалаар, хувиар



Хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг үндсэн чиг үүргийнх нь дагуу үнэлсэн байдлыг авч үзэхэд улсын бүртгэлд шинээр бүртгэх үйлчилгээг 70-аас дээш хувь нь, улсын бүртгэлд өөрчлөлт хийх болон лавлагаа, тодорхойлолт хийх үйлчилгээ, улсын бүртгэлээс хасалт хийх үйлчилгээнд 60-аас дээш хувь байгаа нь нь сайн гэж үнэлснийг илэрхийлж байна.


Иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үндсэн чиг үүргийг “мэдэхгүй” гэж үнэлсэн нь улсын бүртгэлээс хасалт хийх үйлчилгээнд 26.5 хувь, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах үйлчилгээнд 20.2 хувь, улсын бүртгэлд шинээр бүртгэх үйлчилгээг 13.4 хувь, лавлагаа тодорхойлолт авах үйлчилгээнд 14.5 хувь нь тус тус “мэдэхгүй” гэж үнэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг мэдэхгүй иргэдийн тоо нь бага хэмжээгээр өссөн дүр зураг харагдаж байна. Харин хуулийн этгээдүүдийн хувьд үндсэн чиг үүргийг нь “мэдэхгүй” гэж үнэлсэн нь улсын бүртгэлээс хасалт хийх үйлчилгээнд 20.8 хувь, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах үйлчилгээнд 20.8 хувь, улсын бүртгэлд шинээр бүртгэх үйлчилгээг 12.6, тамга тэмдгийн хяналтын хуудас авах үйлчилгээг 12.5 хувь нь “мэдэхгүй” гэж үнэлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад харьцангуй тэнцвэртэй байна.

### 3.2 Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийн үнэлгээ

Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийн үнэлгээг судалгаанд хамрагдсан нийт иргэд, хуулийн этгээдээс тодруулахад дараах үр дүн гарав.

Зураг 3.4

Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийн үнэлгээ



Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийг судалгаанд хамрагдсан иргэдээр үнэлүүлэхэд 6.0 хувь нь муу, 10.0 хувь нь муу, 26.9 хувь нь дундаж, 35.6 хувь нь сайн, 14.6 хувь нь маш сайн, 6.9 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Энэхүү үнэлгээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад маш муу, муу үнэлгээ өгсөн иргэдийн хувь хэмжээ бага зэрэг нэмэгдсэн дүр зургийг харуулж байна. Харин судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хувьд 2.2 хувь нь маш муу, 15.1 хувь нь муу, 25.9 хувь нь дундаж, 35.7 хувь нь сайн, 9.7 хувь маш сайн, 11.4 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Энэхүү хуулийн этгээдийн үнэлгээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуулийн этгээдийн маш муу, муу гэж үнэлсэн үнэлгээ нь өссөн дүр зурагтай харагдаж байна. Үүнээс харахад улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имидж нь иргэд болон хуулийн этгээдийн аль алинд нь дундаж хэмжээнд үнэлэгдсэн байна.

### 3.3 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээнд тулгарч буй хүндрэл, бэрхшээл

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан нийт 690 иргэн, хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлэх хугацаанд ямар нэг хүндрэл, бэрхшээл үүссэн эсэхийг тодруулсан.

2024 онд судалгаанд хамрагдсан 480 иргэний 58.4 хувь нь тийм, 41.6 хувь нь үгүй гэж үнэлсэн. Харин судалгаанд хамрагдсан 210 хуулийн этгээдийн 56.6 хувь нь тийм, 43.4 хувь нь үгүй гэж хариулсан. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын дунджаар 57.5 хувьд нь үйлчилгээ авч буй хугацаанд хүндрэл, бэрхшээл үүсдэг гэж үзсэн.

Зураг 3.5

#### Иргэдийн хувьд үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хувиар



Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдийн хувьд 26.5 хувь нь дараалал ихээс хугацаа алдсан, 10.0 хувь нь үйлчилгээний цагийн хуваарь оновчгүй байдал, 12.9 хувь нь хариу хүлээж хугацаа алдсан, 13.5 хувь нь бүрдүүлэх баримт бичиг хэт олон, 8.5 хувь нь цахим хуудас, мэдээллийн самбарын мэдээлэл дутмаг, 8.6 хувь нь нотариатаар гэрчлүүлэх баримт олон, 6.7 хувь нь бөглөж байгаа маягтын мэдээлэл их, 5.9 хувь нь хураамж, төлбөр төлөх процесс хүндрэлтэй гэж үнэлжээ.

Зураг 3.6

**Хуулийн этгээдийн хувьд үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хувиар**



Улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлж буй хуулийн этгээдийн хувьд 22.2 хувь нь дараалал ихээс хугацаа алдсан, 14.1 хувь нь хариу хүлээж хугацаа алдсан, 15.3 хувь бүрдүүлэх баримт бичиг хэт олон, 10.3 хувь нь цахим хуудас, мэдээллийн самбарын мэдээлэл дутмаг, 9.7 хувь нь нотариатаар гэрчлүүлэх баримт олон, 5.9 хувь нь бөглөж байгаа маягтын мэдээлэл их, 4.4 хувь нь хураамж, төлбөр төлөх процесс хүндрэлтэй, 9.4 хувь нь хураамж, төлбөрийн хэмжээ их, 8.8 хувь нь үйлчилгээний цагийн хуваарь хязгаарлалттай гэж үнэлжээ.

Эдгээр хүндрэл, бэрхшээлийг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

**Үйлчилгээнд тулгарч буй хүндрэл бэрхшээл,  
иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар**

Үзүүлэлт	Иргэн			Хуулийн этгээд			Эд хөрөнгө (Иргэн)			Эд хөрөнгө (Байгууллага)		
	2023	2024	Өөрчлөлт	2023	2024	Өөрчлөлт	2023	2024	Өөрчлөлт	2023	2024	Өөрчлөлт
Дараалал ихээс хугацаа алдсан	23.5	26.4	3.0	22.5	22.2	-0.3	23.9	22.6	-1.3	22.1	23.2	1.1
Хариу хүлээж хугацаа алдсан	15.6	12.9	-2.6	9.4	14.1	4.7	24.3	25.6	1.3	13.2	11.2	-2.0
Бүрдүүлэх баримт бичиг хэт олон	13.7	13.5	-0.2	16.0	15.3	-0.7	12.5	11.2	-1.3	15.3	16.7	1.4
Цахим хуудас, мэдээллийн самбарын мэдээлэл дутмаг	7.7	8.5	0.8	11.5	10.3	-1.2	13.1	12.1	-1.0	14.5	13.2	-1.3
Нотариатаар гэрчлүүлэх баримт олон	9.8	8.6	-1.2	9.6	9.7	0.1	3.1	2.7	-0.4	5.8	7.4	1.6
Бөглөж өгч буй маягтын мэдээлэл их	6.1	6.7	0.6	7.0	5.9	-1.0	6.4	8.2	1.8	12.0	12.4	0.4
Хураамж, төлбөрийн хэмжээ их	6.9	5.9	-1.0	9.1	4.4	-4.7	5.8	5.6	-0.2	6.2	7.2	1.0
Хураамж, төлбөр төлөх процесс хүндрэлтэй	7.0	7.4	0.3	7.8	9.4	1.6	10.9	12.0	1.1	10.9	8.7	-2.2

Улсын бүртгэлийн байгууллагын иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн (иргэн, аж ахуй нэгж байгууллага) үйлчилгээнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг дээрх хүснэгтээр харууллаа. Иймээс үйлчилгээнд тулгамдаж буй хүндрэл, бэрхшээлүүд нь өмнөх жилийн мөн үеэс өссөн үзүүлэлттэй асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж, хэрэглэгчдийг чирэгдэлгүй үйлчлэх тал дээр анхаарах хэрэгцээтэй байна.

#### 4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ


##### 4.1 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарын үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг авахад шаардагдах хугацааг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 6.0 хувь нь маш муу, 10.0 хувь нь муу, 26.9 хувь нь дундаж, 35.6 хувь нь сайн, 14.6 хувь нь маш сайн, 6.9 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 2.2 хувь нь маш муу, 15.1 хувь нь муу, 25.9 хувь нь дунд, 35.7 хувь нь сайн, 9.7 маш сайн, 11.4 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчид нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад иргэдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр болсон нь харагдаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээг дунджаар ямар хугацаанд авч буйг судалгаанд хамрагдсан нийт 690 иргэн, хуулийн этгээдээс тодруулахад дараах үр дүн гарав. Үүнд:

Зураг 4.1


##### Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 23.8 хувь нь ажлын 1 хоногт, 37.2 хувь нь ажлын 3 хоногт, 25.0 хувь нь ажлын 5 хоногт, 14.2 хувь нь ажлын 5 хоноогоос дээш хугацаанд үйлчилгээ авдаг байна. Харин судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хувьд 17.3 хувь нь ажлын 1 хоногт, 49.7 хувь нь ажлын 3 хоногт, 21.1 хувь нь ажлын 5 хоногт, 11.9 хувь нь ажлын 5 хоноогоос дээш Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээ авсан хугацааг бүртгэлийн төрлөөр нь өнгөрсөн оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлснийг доорх байдлаар харуулав.

Зураг 4.2

Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, бүртгэлийн төрлөөр  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар




Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлж үзэхэд ажлын 3 хоногт үйлчилгээ авч буй нь 2.9 пунктээр өссөн бол ажлын 1 хоногт үйлчилгээ авч буй нь 0.5 пунктээр, ажлын 5 хоногт үйлчилгээ авч буй нь 2.4 пунктээр, ажлын 5-аас дээш хоногт үйлчилгээ авч буй нь 1.6 пунктээр тус тус буурсан байна. Өөрөөр хэлбэл иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг ажлын 3 хоногт авч буй нь дийлэнх хэсгийг эзэлж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлж үзэхэд ажлын 1 хоногт үйлчилгээ авч буй нь 5.1 пунктээр өссөн бол ажлын 3 хоногт үйлчилгээ авч буй нь 2.9 пунктээр, ажлын 5 хоногт үйлчилгээ авч буй нь 1.5 пунктээр, ажлын 5-аас илүү хоногт үйлчилгээ авч буй нь 0.7 пунктээр тус тус буурсан байна. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг ажлын 3 хоногт авч буй нь дийлэнх хэсгийг эзэлж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг өмнөх оны судалгааны үр дүнтэй зэрэгцүүлж үзэхэд ажлын 5-аас хоногт үйлчилгээ авч буй нь 5.7 пунктээр буурсан бол ажлын 3 хоногт үйлчилгээ авч буй нь 1.7 пунктээр, ажлын 5 хоногт үйлчилгээ авч буй нь 2.3 пунктээр, ажлын 1 хоногт үйлчилгээ авч буй нь 1.9 пунктээр тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг ажлын 3 хоногт авч буй нь дийлэнх хэсгийг эзэлж байгаа ч ажлын 5-с дээш хоногт үйлчлүүлэгчдийн тоо нь өссөөр байна.

Зураг 4.3

**Үйлчилгээ авч буй дундаж хугацаа, иргэн болон хуулийн этгээдийн ялгаатай байдлаар, хувиар**




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг авахад 37.0 хувь нь 3-аас бага, 48.5 хувь нь 4-6 төрлийн бичиг баримт, 6.3 хувь нь 7-10 төрлийн бичиг баримт, үлдэх 8.2 хувь нь 10-аас дээш тооны бичиг баримтыг бүрдүүлж үйлчлүүж байна. Харин судалгаанд хамрагдсан хуулийн этгээдийн хувьд 16.2 хувь нь 3-аас бага, 36.8 хувь нь 4-6 төрлийн бичиг баримт, 29.2 хувь нь 7-10 төрлийн бичиг баримт, үлдэх 17.9 хувь нь 10-аас дээш тооны бичиг баримтыг бүрдүүлж үйлчлүүлдэг байна. Үүнээс үзэхэд иргэдийн хувьд улсын бүртгэлийн үйлчилгээг авахдаа бүрдүүлэх материалын тоо багассан нь илэрхий харагдаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлэхэд дараах үндсэн үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар
- Ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал
- Санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо
- Эргэх холбоо, хариу үйлдэл гэсэн үзүүлэлтээр таван хэмжээст оноогоор нийт судалгаанд оролцогчдын үнэлгээг авахад дараах үр дүн гарав.



**Үйлчилгээний чанарын үзүүлэлт  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар**



Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.13 (82.6%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.12 (82.4%)-аас 0.01 оноо буюу 0.2 пунктээр өсчээ.

Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар 0.02 пунктээр, санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо нь 0.09 пунктээр, эргэх холбоо, хариу мэдээлэл өгдөг байдал нь 0.05 пунктээр тус тус өссөн бол ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал нь 0.01 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарт өгөх сэтгэл ханамжийн бодит үнэлгээг тооцоход дараах үр дүн гарав.

**Хүснэгт 4.1**

**Үйлчилгээний чанарын талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**

Д/д	Хүчин зүйлс	Ач холбогдол	Үнэлгээ	Ач холбогдолд (1-д суурилсан дундаж) С	Бодит үнэлгээ D=B*С
1	Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар	4.81	4.37	1.16	4.99
2	Ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал	3.99	3.71	0.97	3.59

3	Санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо	3.91	3.68	0.95	3.50
4	Эргэх холбоо, хариу үйлдэл	3.82	3.70	0.92	3.41
	Дундаж	4.13	3.86	1.00	4.22

Үйлчилгээний чанарын талаарх сэтгэл ханамжийн индексийг дараах томъёогоор тооцож олно.

$$\text{Ач холбогдлын түвшний дундаж: } \bar{x} = \frac{\sum x}{\sum p} = \frac{16.53}{4} = 4.13$$

$$\text{Үнэлгээний дундаж: } \bar{y} = \frac{\sum y}{\sum p} = \frac{15.46}{4} = 3.86$$

Ач холбогдлын 1-д суурилсан дунджийг олоход:

$$\bar{X}_1 = \frac{X_1}{\bar{x}} = \frac{4.81}{4.13} = 1.16$$

$$\bar{X}_2 = \frac{X_2}{\bar{x}} = \frac{3.99}{4.13} = 0.97$$

$$\bar{X}_3 = \frac{X_3}{\bar{x}} = \frac{3.91}{4.13} = 0.95$$

$$\bar{X}_4 = \frac{X_4}{\bar{x}} = \frac{3.82}{4.13} = 0.92$$

Хэрэглэгчийн бодит үнэлгээ:

$$Y'_1 = Y_1 * \bar{X}_1 = 4.37 * 1.16 = 4.99$$

$$Y'_2 = Y_2 * \bar{X}_2 = 3.71 * 0.97 = 3.59$$

$$Y'_3 = Y_3 * \bar{X}_3 = 3.68 * 0.95 = 3.50$$

$$Y'_4 = Y_4 * \bar{X}_4 = 3.70 * 0.92 = 3.41$$

$$CSI = \frac{\sum Y'}{\sum P} = \frac{16.88}{4} = 4.22$$

Судалгаанд оролцсон нийт иргэн болон хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарт өгөх ерөнхий сэтгэл ханамжийн индекс нь 3.87 оноотой гарч буй нь “Дундаас дээш” түвшинд байгааг илтгэж байна.

**Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц**



Дээрхи матрицаас харахад судалгаанд хамрагдсан оролцогчид нь ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар (4.99), ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал (3.59) санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо (3.50), эргэх холбоо, хариу үйлдэл (3.86) хэмээн тус тус үнэлсэн нь сэтгэл ханамж дундаас дээгүүр байгааг илтгэж байна.

**4.2 Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**


Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 10.3 хувь нь маш муу, 13.4 хувь нь муу, 28.4 хувь нь дундаж, 33.3 хувь нь сайн, 12.1 хувь нь маш сайн, 2.4 хувь нь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 7.4 хувь нь маш муу, 13.2 хувь нь муу, 29.2 хувь нь дунд, 28.7.0 хувь нь сайн, 19.1 хувь нь маш сайн, 2.4 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд үйлчилгээний хүртээмжийг дундаас дээгүүр үнэлж буй хэсэг нь дийлэнх хэсгийг эзэлж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлэхэд дараах үндсэн үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж
- Үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь
- Маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ
- Үйлчилгээ үзүүлэх маягт, зааварчилгаа, ойлгомжтой хялбар эсэх
- Үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал
- Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг авах боломжтой байдал гэсэн үзүүлэлтээр таван хэмжээст оноогоор нийт судалгаанд оролцогчдын үнэлгээг авахад дараах үр дүн гарав.

Зураг 4.6

**Үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлт  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар**



Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.24 (84.8%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.22 (84.4%)-оос 0.02 оноо буюу 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж нь 0.04 пунктээр, маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ нь 0.06 пунктээр, үйлчилгээ үзүүлэх маягт зааварчилгаа, ойлгомжтой байдал нь 0.03 пунктээр, үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал нь 0.03 пунктээр, улсын бүртгэлийн ажилтнаас зөвлөгөө авах боломжтой байдал нь 0.06 пунктээр өссөн бол үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь нь 0.05 пунктээр буурсан өөрчлөлт харагдаж байна.

Нийт судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжид өгөх сэтгэл ханамжийн бодит үнэлгээг тооцоход дараах үр дүн гарав.

**Хүснэгт 4.2**

**Үйлчилгээний хүртээмжийн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**

Д/д	Хүчин зүйлс	Ач холбогдол	Үнэлгээ	Ач холбогдолд (1-д суурилсан дундаж) С	Бодит үнэлгээ D=B*C
1	Үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж	3.96	3.92	0.92	3.61
2	Үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь	4.23	4.12	0.99	4.08
3	Маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ	4.71	4.43	1.10	4.87
4	Үйлчилгээ үзүүлэх, маягт, зааварчилгаа ойлгомжтой хялбар эсэх	4.47	4.29	1.05	4.50
5	Үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал	4.01	4.00	0.94	3.76
	Дундаж	4.28	4.15	1.00	4.16

Үйлчилгээний хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийн индексийг дараах томъёогоор тооцож олно.

$$\text{Ач холбогдлын түвшний дундаж: } \bar{x} = \frac{\sum x}{\sum p} = \frac{21.38}{5} = 4.28$$

$$\text{Үнэлгээний дундаж: } \bar{y} = \frac{\sum y}{\sum p} = \frac{20.76}{5} = 4.15$$

Ач холбогдлын 1-д суурилсан дунжийг олоход:

$$\bar{X}_1 = \frac{X_1}{\bar{x}} = \frac{3.96}{4.28} = 0.92$$

$$\bar{X}_2 = \frac{X_2}{\bar{x}} = \frac{4.23}{4.28} = 0.99$$

$$\bar{X}_3 = \frac{X_3}{\bar{x}} = \frac{4.71}{4.28} = 1.10$$

$$\bar{X}_4 = \frac{X_4}{\bar{x}} = \frac{4.47}{4.28} = 1.05$$

$$\bar{X}_5 = \frac{X_5}{\bar{x}} = \frac{4.01}{4.28} = 0.94$$

Хэрэглэгчийн бодит үнэлгээ:

$$Y'_1 = Y_1 * \bar{X}_1 = 3.92 * 0.92 = 3.61$$

$$Y'_2 = Y_2 * \bar{X}_2 = 4.12 * 0.99 = 4.08$$

$$Y'_3 = Y_3 * \bar{X}_3 = 4.43 * 1.10 = 4.87$$

$$Y'_4 = Y_4 * \bar{X}_4 = 4.29 * 1.05 = 4.50$$

$$Y'_5 = Y_5 * \bar{X}_5 = 4.00 * 0.94 = 3.76$$

$$CSI = \frac{\sum Y'}{\sum P} = \frac{20.82}{5} = 4.16$$

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын хувьд улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжид өгөх ерөнхий сэтгэл ханамжийн индекс нь 4.16 оноотой гарч буй нь “Сайн” түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 4.7

**Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц**



Дээрхи матрицаас харахад судалгаанд хамрагдсан оролцогчид нь үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж (3.61), үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь (4.08), маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ (4.87), үйлчилгээ үзүүлэх, маягт, зааварчилгаа ойлгомжтой хялбар эсэх (4.50), үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал (3.76) хэмээн тус тус үнэлсэн нь сэтгэл ханамж сайн байгааг илтгэж байна.

**4.3 Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**


Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 8.8 хувь нь маш муу, 9.7 хувь нь муу, 32.3 хувь нь дундаж, 28.7 хувь нь сайн, 18.6 хувь нь маш сайн, 0.9 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 5.9 хувь нь маш муу, 17.8 хувь нь муу, 18.8 хувь нь дунд, 38.5 хувь нь сайн, 16.4 хувь нь маш сайн, 2.6 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд үйлчилгээний ажилтаны харилцаа, ёс зүйг “Дундаас дээш” гэж үнэлж буй хэсэг нь дийлэнх хэсгийг эзэлж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйг дараах үндсэн үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Үйлчлүүлэгчдэд туслахад бэлэн, түргэн шуурхай үйлчлэх байдал
- Эелдэг, таатай харилцаа
- Бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах
- Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал
- Зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх
- Ажилтнуудын цаг баримтлах, цагийн зөв зохион байгуулах чадвар
- Шударга байх, хууль дээдлэх гэсэн үзүүлэлтээр таван хэмжээст оноогоор нийт судалгаанд оролцогчдын үнэлгээг авахад дараах үр дүн гарав.

**Зураг 4.8**

**Үйлчилгээний ажилтны харилцааны соёл, ёс зүй  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар**



Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний ажилтаны соёл, ёс зүйг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.40 (88.0%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.47 (89.4%)-оос 0.07 оноо буюу 1.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Ажилтнуудын цаг баримтлах, цагийг зохион байгуулах байдал нь 0.11 пунктээр, шударга байх, хууль дээдлэх байдал нь 0.08 пунктээр тус тус өссөн бол хэрэглэгчдэд зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх нь 0.19 пунктээр, ажилдаа хариуцлагатай ханддаг байдал нь 0.24 пунктээр, эелдэг таатай харилцаа 0.13 пунктээр, бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах байдал 0.04 пунктээр, зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх байдал 0.06 пунктээр тус тус буурсан өөрчлөлт харагдаж байна.

Нийт судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудын харилцааны соёл, ёс зүйд өгөх сэтгэл ханамжийн бодит үнэлгээг тооцоход дараах үр дүн гарав.

**Хүснэгт 4.3**

**Ажилтны харилцаа, ёс зүйн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**

Д/д	Хүчин зүйлс	Ач холбогдол	Үнэлгээ	Ач холбогдолд (1-д суурилсан дундаж) С	Бодит үнэлгээ D=B*C
1	Үйлчлүүлэгчдэд туслахад бэлэн, түргэн шуурхай үйлчлэх байдал	4.22	4.32	0.96	4.15
2	Эелдэг, таатай харилцаа	4.21	4.26	0.96	4.09
3	Бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах	4.41	4.39	1.00	4.39
4	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	4.21	4.38	0.96	4.20
5	Зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх	4.32	4.28	0.98	4.19
6	Ажилтнуудын цаг баримтлах, цагийн зөв зохион байгуулах чадвар	4.59	4.11	1.04	4.27
7	Шударга байх, хууль дээдлэх	4.84	4.28	1.10	4.70
	Дундаж	4.40	4.29	1.00	4.29

Ажилтаны харилцааны соёл, ёс зүйн талаарх сэтгэл ханамжийн индексийг дараах томъёогоор тооцож олно.



Ач холбогдлын түвшний дундаж:  $\bar{x} = \frac{\sum x}{\sum p} = \frac{30.8}{7} = 4.40$

Үнэлгээний дундаж:  $\bar{y} = \frac{\sum y}{\sum p} = \frac{30.02}{7} = 4.29$

Ач холбогдлын 1-д суурилсан дунджийг олоход:

$$\bar{X}_1 = \frac{X_1}{\bar{x}} = \frac{4.22}{4.40} = 0.96$$

$$\bar{X}_2 = \frac{X_2}{\bar{x}} = \frac{4.21}{4.40} = 0.96$$

$$\bar{X}_3 = \frac{X_3}{\bar{x}} = \frac{4.41}{4.40} = 1.00$$

$$\bar{X}_4 = \frac{X_4}{\bar{x}} = \frac{4.21}{4.40} = 0.96$$

$$\bar{X}_5 = \frac{X_5}{\bar{x}} = \frac{4.32}{4.40} = 0.98$$

$$\bar{X}_6 = \frac{X_6}{\bar{x}} = \frac{4.59}{4.40} = 1.04$$

$$\bar{X}_7 = \frac{X_7}{\bar{x}} = \frac{4.84}{4.40} = 1.10$$

Хэрэглэгчийн бодит үнэлгээ:

$$Y'_1 = Y_1 * \bar{X}_1 = 4.32 * 0.96 = 4.15$$

$$Y'_2 = Y_2 * \bar{X}_2 = 4.26 * 0.96 = 4.09$$

$$Y'_3 = Y_3 * \bar{X}_3 = 4.39 * 1.00 = 4.39$$

$$Y'_4 = Y_4 * \bar{X}_4 = 4.38 * 0.96 = 4.20$$

$$Y'_5 = Y_5 * \bar{X}_5 = 4.28 * 0.98 = 4.19$$

$$Y'_6 = Y_6 * \bar{X}_6 = 4.11 * 1.04 = 4.27$$


$$Y'_7 = Y_7 * \bar{X}_7 = 4.28 * 1.10 = 4.70$$

$$CSI = \frac{\sum Y'}{\sum P} = \frac{29.99}{7} = 4.28$$

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын хувьд улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудын харилцааны ёс зүй, соёлд өгөх ерөнхий сэтгэл ханамжийн индекс нь 4.28 оноотой гарч буй нь “Сайн” түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 4.9

**Улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудын харилцааны ёс зүй, соёлыг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц**



Дээрхи матрицаас харахад судалгаанд хамрагдсан оролцогчид нь үйлчлүүлэгчдэд туслахад бэлэн, түргэн шуурхай үйлчлэх байдал (4.15), эелдэг таатай харилцаа (4.09), бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах байдал (4.39), ажилдаа хариуцлагатай ханддаг байдал (4.20), зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх байдал (4.19), ажилтнуудын цаг баримтлах, цаг зохион байгуулах чадвар (4.27), шударга байх, хууль дээдлэх байдал (4.70) хэмээн тус тус үнэлсэн нь сэтгэл ханамж сайн байгааг илтгэж байна.

**4.4 Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийн үнэлгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**


Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 7.8 хувь нь маш муу, 11.2 хувь нь муу, 27.7 хувь нь дундаж, 34.1 хувь нь сайн, 16.4 хувь нь маш сайн, 2.8 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 7.3 хувь нь маш муу, 10.7 хувь нь муу, 27.4 хувь нь дунд, 22.4 хувь нь сайн, 28.5 хувь нь маш сайн, 3.7 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын орчин өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад өссөн дүр зураг харагдаж байна.

Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг дараах үндсэн үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал
- Дотоод орчны цэвэр, тав тухтай байдал
- Танхим, ширээ сандалны хүрэлцээ
- Гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал
- Автомашины зогсоолын хүрэлцээ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх гэсэн үзүүлэлтээр таван хэмжээст оноогоор нийт судалгаанд оролцогчдын үнэлгээг авахад дараах үр дүн гарав.

Зураг 4.10

**Байгууллагын орчин нөхцлийг үнэлсэн байдал  
2023 болон 2024 оны зэрэгцүүлсэн байдлаар**



Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.32 (86.4%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.29 (85.8%)-өөс 0.03 оноо буюу 0.6 пунктээр өссөн байна.

Гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал нь 0.51 пунктээр, дотоод орчны цэвэр, тав тухтай байдал 0.08 пунктээр, танхим

ширээ сандалны хүрэлцээ 0.27 пунктээр, гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал 0.42 пунктээр, автомашины зогсоолын хүрэлцээ 0.29 пунктээр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд таатай орчин бүрдүүлсэн байдал 0.46 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцөлд өгөх сэтгэл ханамжийн бодит үнэлгээг тооцоход дараах үр дүн гарав.

**Хүснэгт 4.4**

**Байгууллагын орчин нөхцлийн талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн тооцоолол**

Д/д	Хүчин зүйлс	Ач холбогдол	Үнэлгээ	Ач холбогдолд (1-д суурилсан дундаж) С	Бодит үнэлгээ D=B*C
1	Гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал	4.96	4.05	1.15	4.66
2	Дотоод орчны цэвэр, тав тухтай байдал	4.47	4.21	1.04	4.38
3	Танхим, ширээ сандалны хүрэлцээ	4.31	3.88	0.99	3.84
4	Гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал	4.56	3.78	1.06	4.01
5	Автомашины зогсоолын хүрэлцээ	3.88	3.32	0.90	2.99
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх	3.76	3.38	0.87	2.94
	Дундаж	4.32	3.77	1.00	4.80

Байгууллагын орчин нөхцлийн талаарх сэтгэл ханамжийн индексийг дараах томъёогоор тооцож олно.

$$\text{Ач холбогдлын түвшний дундаж: } \bar{x} = \frac{\sum x}{\sum p} = \frac{25.94}{6} = 4.32$$

$$\text{Үнэлгээний дундаж: } \bar{y} = \frac{\sum y}{\sum p} = \frac{22.62}{6} = 3.77$$

Ач холбогдлын 1-д суурилсан дунджийг олоход

$$\bar{X}_1 = \frac{X_1}{\bar{x}} = \frac{4.96}{4.32} = 1.15$$

$$\bar{X}_2 = \frac{X_2}{\bar{x}} = \frac{4.47}{4.32} = 1.04$$

$$\bar{X}_3 = \frac{X_3}{\bar{x}} = \frac{4.31}{4.32} = 0.99$$

$$\bar{X}_4 = \frac{X_4}{\bar{x}} = \frac{4.56}{4.32} = 1.06$$

$$\bar{X}_5 = \frac{X_5}{\bar{x}} = \frac{3.88}{4.32} = 0.90$$

$$\bar{X}_6 = \frac{X_6}{\bar{x}} = \frac{3.76}{4.32} = 0.87$$

Хэрэглэгчийн бодит үнэлгээ:

$$Y'_1 = Y_1 * \bar{X}_1 = 4.05 * 1.15 = 4.66$$

$$Y'_2 = Y_2 * \bar{X}_2 = 4.21 * 1.04 = 4.38$$

$$Y'_3 = Y_3 * \bar{X}_3 = 3.88 * 0.99 = 3.84$$

$$Y'_4 = Y_4 * \bar{X}_4 = 3.78 * 1.06 = 4.01$$

$$Y'_5 = Y_5 * \bar{X}_5 = 3.32 * 0.90 = 2.99$$


$$Y'_6 = Y_6 * \bar{X}_6 = 3.38 * 0.87 = 2.94$$

$$ESI = \frac{\sum Y'}{\sum P} = \frac{22.82}{6} = 4.80$$

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын хувьд улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцөлд өгөх ерөнхий сэтгэл ханамжийн индекс нь 3.80 оноотой гарч буй нь “Дундаас дээгүүр” түвшинд байгааг илтгэж байна.

Зураг 4.11

**Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг үнэлсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийн матриц**



Дээрхи матрицаас харахад судалгаанд хамрагдсан оролцогчид нь гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал (4.66), дотоод орчны цэвэр, тав тухтай байдал (4.38), танхим, ширээ сандалны хүрэлцээ (3.84),

гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал (4.01), зөвлөгөө өгч, автомашины зогсоолын хүрэлцээ (2.99), хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх (2.94) хэмээн тус тус үнэлсэн нь сэтгэл ханамж сайн байгааг илтгэж байна.

Судалгааны тайлангийн энэхүү хэсэгт улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх үнэлгээг 4 дэд хэсэгт (үйлчилгээний чанар, үйлчилгээний хүртээмж, ажилтаны харилцааны ёс зүй, соёл, орчин нөхцөл) нарийвчлан судалж, үзүүлэлт бүр дээр сэтгэл ханамжийн тооцооллыг гүйцэтгэж, өмнөх оны судалгааны үр дүнгүүдтэй харьцуулахад доорх үр дүн гарав.

**Хүснэгт 4.5**

**Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны хэрэглэгчийн ерөнхий үнэлгээ**

Хэрэглэгчийн үнэлгээ	Оноо
Үйлчилгээний чанарын үнэлгээ	4.28
Үйлчилгээний хүртээмжийн үнэлгээ	4.16
Үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүйн үнэлгээ	4.28
Үйлчилгээний орчин, нөхцлийн үнэлгээ	4.80
Дундаж	4.38

Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны чиглэл бүрээр нь үнэлүүлэхэд ерөнхий дундаж үнэлгээ нь 4.39 (87.6%) гарчээ. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны 2023 оны үйл ажиллагаа нь 4.32 (86.4%) байсан бол энэ онд 0.07 пункт буюу 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## 5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖҮҮД

### 5.1 Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн судалгааны дүгнэлт

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэд, аж ахуй нэгжид хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэн, аж ахуй нэгж байгууллагуудаас танигдалт, сэтгэл ханамж, хандлагыг тандан судалж, түүний үр дүнд зарим тоон шинжилгээг хийсний үндсэн дээр цаашид үйл ажиллагааг сайжруулах чиглэлийн бодлого, үйл ажиллагаанд санал дэвшүүлэх зорилгын хүрээнд судлагдсан “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний судалгааг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан 690 иргэн, хуулийн этгээдийг хамруулан судалсан. Тус судалгааг иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл гэсэн 3 чиглэлд хийсэн. Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтүүдийг хүргүүлж байна.

- Энэхүү судалгааны агуулгын дагуух үр дүнд тулгуурлан, судалгаанд оролцогчдын санал, хүсэлтэд үндэслэн байгууллагын танигдсан байдал, үйлчилгээний чанар, үйлчилгээний хүртээмж, ажилтаны харилцааны ёс зүй, байгууллагын орчин нөхцөл гэсэн дэд хэсэг бүрээр нь нэгтгэн дүгнэхэд 2024 оны үйл ажиллагааны ерөнхий дундаж үнэлгээ нь 4.39 (87.8%) гарчээ. Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны 2023 оны үйл ажиллагаа нь 4.32 (86.4%) байсан бол энэ онд 0.07 пункт буюу 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Хэрэглэгчид бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг хэр хэмжээнд мэддэг байдлын үнэлүүлэхэд 80 орчим хувь нь дундаас дээш түвшний мэдлэгтэй байгааг харуулсан. Өмнөх онтой зэрэгцүүлэхэд хэрэглэгчийн мэдлэгийн түвшин тодорхой хэмжээгээр өссөн хандлага байгаа ч мэдэхгүй хэрэглэгчийн тоо бас өссөн дүр зурагтай байна. Түүнчлэн бүртгэлийн байгууллагын үйлчилгээг авч буй хуулийн этгээдүүдийн мэдлэг нь иргэдээс харьцангуй өндөр байгаа нь өмнөх жилийн мөн үетэй ижил түвшинд байна.

- Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг авахад шаардагдах хугацааг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 6.0 хувь нь маш муу, 10.0 хувь нь муу, 26.9 хувь нь дундаж, 35.6 хувь нь сайн, 14.6 хувь нь маш сайн, 6.9 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 2.2 хувь нь маш муу, 15.1 хувь нь муу, 25.9 хувь нь дунд, 35.7 хувь нь сайн, 9.7 маш сайн, 11.4 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан нийт хэрэглэгчид бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг 4.13 (82.6%) үнэлгээтэй өгсөн нь өмнөх оны үнэлгээ болох 4.12 (82.4%)-аас 0.01 оноо буюу 0.2 пунктээр өсчээ.
- Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 10.3 хувь нь маш муу, 13.4 хувь нь муу, 28.4 хувь нь дундаж, 33.3 хувь нь сайн, 12.1 хувь нь маш сайн, 2.4 хувь нь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 7.4 хувь нь маш муу, 13.2 хувь нь муу, 29.2 хувь нь дунд, 28.7.0 хувь нь сайн, 19.1 хувь нь маш сайн, 2.4 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд үйлчилгээний хүртээмжийг дундаас дээгүүр үнэлж буй хэсэг нь дийлэнх хэсгийг эзэлж байна. 2024 оны улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.24 (84.8%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.22 (84.4%)-оос 0.02 оноо буюу 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.
- Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 8.8 хувь нь маш муу, 9.7 хувь нь муу, 22.3 хувь нь дундаж, 28.7 хувь нь сайн, 28.6 хувь нь маш сайн, 0.9 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 5.9 хувь нь маш муу, 7.8 хувь нь муу, 18.8 хувь нь дунд, 38.5 хувь нь сайн, 26.4 хувь нь маш сайн, 2.6 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд үйлчилгээний ажилтаны харилцаа, ёс зүйг “сайн” гэж үнэлж буй хэсэг нь дийлэнх хэсгийг эзэлж байна. Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний ажилтаны соёл, ёс зүйг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.49 (89.8%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.47 (89.4%)-оос 0.02 оноо буюу 0.4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.
- Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 7.8 хувь нь маш муу, 11.2 хувь нь муу, 27.7 хувь нь дундаж, 34.1 хувь нь сайн, 16.4 хувь нь маш сайн, 2.8 хувь мэдэхгүй гэсэн байр сууриа



илэрхийлсэн. Харин хуулийн этгээдийн хувьд 7.3 хувь нь маш муу, 10.7 хувь нь муу, 27.4 хувь нь дунд, 22.4 хувь нь сайн, 28.5 хувь нь маш сайн, 3.7 хувь нь мэдэхгүй гэж үнэлсэн. Үүнээс харахад иргэд болон хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн байгууллагын орчин өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад өссөн дүр зураг харагдаж байна. Дээрх үзүүлэлтүүдээр улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцлийг үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.32 (86.4%) үнэлгээтэй байгаа нь өмнөх оны үнэлгээ болох 4.29 (85.8%)-өөс 0.03 оноо буюу 0.6 пунктээр өссөн байна.

Иймд хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнд тулгуурлан бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах дэд хэсэг бүрт санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

## **5.2 Байгууллагын танигдсан байдал болон хэрэглэгчийн үнэлгээг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд**

Хэрэглэгчдэд бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг таниулах, мэдээлэл авч буй эх сурвалжуудыг нэмэгдүүлэх чиглэлд дараах санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг хэрэглэгчдэд таниулахад албан ёсны эх сурвалжаар мэдээ, мэдээллийг ойлгомжтой бүрэн өгөх, аль болох цаг хугацааг хэмнэх чиглэлээр онлайн байдлаар хүргэх
- Хэрэглэгчид нь мэдээллийг нийгмийн сүлжээ (Facebook, Twitter), байгууллагын лавлах утас, байгууллагын албан ёсны веб хуудас зэрэг орчин цагийн зар сурталчилгааны хэрэглсүүдийг түлхүү сонгон хэрэглэж байгаа учраас тэр чиглэлийн сувгуудыг ашиглахад анхаарах
- Бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд цацаж байгаа өнөөгийн байдлыг илүү сайжруулж, олон төрлийн сувгуудаар мэдээллийг цацах хэрэгцээ байгааг анхаарч, байгууллагын мэдээллийг түгээх, үйлчилгээний цэг дэх мэдээллийг оновчтой өгөхөд анхаарах, шаардлагатай зардлыг нэмэгдүүлэн төсөвлөх
- Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг иргэд болон хуулийн этгээдүүдэд хоногшуулах, байгууллагын өнгө төрх, имиджээр бусад төрийн байгууллагуудаас ялгарах

- Үйлчилгээний цэгүүдийн тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой болгож, хэрэглэгчдэд үйлчлэхэд хөтөч мэргэжилтэнг бий болгох
- Улсын бүртгэлийн үйлчилгээг цахимаар авч буй хэрэглэгчийн тоо жилээс жилд өсөж буйтай холбоотойгоор E-Mongolia цахим порталын зарим төрлийн үйлчилгээг илүү хялбаршуулах, бүх цэгүүдийн ТҮЦ машины бүрэн ажиллагаанд анхаарч ажиллах, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлах бүртгэгчийн тоог нэмэгдүүлэх
- Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээнд тулгарч буй хэрэглэгчдэд хүндрэл, чирэгдэл бий болгож байгаа зарим асуудалд (дараалал ихээх хугацаа алддаг, хариу хүлээж хугацаа алддаг, дараалал ихтэйгээс хугацаа алддаг, бүрдүүлэх бичиг баримт их, нотариатаар гэрчлүүлэх баримт их гэх мэт) олон улсын чиг хандлагыг судалж, шат дараалсан сайжруулах чиглэлийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг санал, зөвлөмжийг судалгааны үр дүн, судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хүсэлт, гомдолд тулгуурлан дэвшүүлж байна.

### 5.3 Үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд

Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг илүү сайжруулахын тулд дараах санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Үйлчилгээ авч буй хэрэглэгчдэд мэдээллийг тодорхой өгч, нэг удаагийн хандалтаар асуудлыг хүндрэл, хүнд сурталгүйгээр өгч, эерэг хандлага харилцаатайгаар үйлчилгээг үзүүлэх
- Үйлчилгээний цэг бүр дэх бүртгэгчийн тооны нормативт анхаарч, нэг цонх дээр үйлчлэх бүртгэгчийн тоог стандартчилж, хэрэглэгчдэд дугаар дараалал үүсгэх нөхцлийг бага байлгахад анхаарах
- Үйлчилгээ үзүүлж буй хугацааг аль болох богиносгох чиглэлд анхаарч, олон өдөр шаардагддаг үйлчилгээний тоог бууруулах
- Үйлчилгээ авахад хэрэглэгчдэд чирэгдэл үүсгэж буй олон төрлийн баримт болон нотариат хийлгэсэн байх шаардлагатай материалын тоог багасгах, цаашид баримт, материалыг цахимжуулах, түүнийг үйлчилгээнд хэвшүүлэх
- Үйлчилгээний талаарх санал, гомдол хүлээн авах тогтолцоог сайжруулж, иргэд болон хуулийн этгээдтэй үйлчилгээний стандартын дагуу эргэх холбоотой

ажиллах зэрэг санал, зөвлөмжийг судалгааны үр дүн, судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хүсэлт, гомдолд тулгуурлан дэвшүүлж байна.

#### **5.4 Үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд**

Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлд дараах санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Улсын хэмжээнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй бүх цэгүүдэд дугаар олгох машиныг байршуулах, бүрэн ажиллагаатай байлгах
- Үйлчилгээ үзүүлж буй нэг цэгийн үйлчилгээ, бүртгэлийн хэлтсүүдэд хэрэглэгчдийг хүндрэл, чирэгдэлгүй үйлчлүүлэх нөхцлөөр хангах, сонгосон үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй тайлбар өгөх хөтөч мэргэжилтнийг бий болгох
- Газар зүйн байршил, хүн амын тоо зэргээс хамааралтайгаар аймаг, нийслэл, сум, дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв, бүртгэлийн хэлтэс, ТҮЦ машины тоог нэмэгдүүлэх
- Цахим, онлайн-ар үзүүлэх боломжтой үйлчилгээний төрлийг нэмэх зэрэг санал, зөвлөмжийг судалгааны үр дүн, судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хүсэлт, гомдолд тулгуурлан дэвшүүлж байна.
- Хэрэглэгчдэд ихээхэн чирэгдэл үүсгэж буй үйлчилгээний төлбөр, хураамж төлөх, баримт материалыг нотариатжуулах зэрэг асуудлуудыг цахим байдлаар шийдэх боломжийг эрэлхийлэх
- Үйлчилгээ үзүүлж буй нэг цэгийн үйлчилгээний төв, бүртгэлийн хэлтсүүдийн хаягжилтад анхаарч мэдээллийн самбарын мэдээллийг тодорхой, ойлгомжтой болгох, хяналт тавих

#### **5.5 Үйлчилгээг үзүүлж буй ажилтаны харилцаа, ёс зүйн талаар сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд**

Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг үзүүлж буй ажилтаны харилцааны соёл, ёс зүйг сайжруулах чиглэлд дараах санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Хэрэглэгчидтэй эелдэг, таатай байдлаар харилцах, сэтгэл ханамжтай үйлчлүүлэх боломжийг олгохын тулд үйлчилгээний ажилтнуудыг

чадавхижуулах, эерэг хандлага, харилцааг төлөвшүүлэх сургалтын хэрэгцээг тодорхойлох, үе шаттайгаар сургалтыг зохион байгуулах

- Шинээр ажилд орсон ажилтнуудыг чадавхижуулах, ээлжийн амралттай болон дотоод ажилтай ажилтнуудын оронд нөхөн ажиллах бүртгэгчийг томилох замаар хэрэглэгчдэд төвөг, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарах
- Төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд ил тод, нээлттэй хүргэхийн тулд хүнд сурталгүй, ёс зүйтэй, хариуцлагатай үйлчлэх чиглэлийг баримтлан бүртгэгчдийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх
- Тухайн ажилтаны туршлага, мэдлэг чадвар, хандлага дутмаг байдлаас үүдэлтэйгээр хэрэглэгчдэд замбараагүй тайлбар өгөх, шаардлагагүй баримт нэхэх, харилцааны хувьд доголдол гаргаж буй байдлыг бууруулах
- Зарим хэрэглэгчдийн бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдлэг дутмаг байдгаас үүдэлтэйгээр үйлчилгээний ажилтанд чирэгдэл үүсгэж буй байдлыг хяналтад байлгаж, хэрэглэгчдээс ирэх чирэгдлийг бууруулах

## **5.6 Үйлчилгээний байгууллагын орчин болон тохижилтыг сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүд**

Бүртгэлийн байгууллагын орчин, нөхцлийг сайжруулах чиглэлд дараах санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- Үйлчилгээний танхимд байрлах маягт, зааврыг хүрэлцээтэй, ил байлгах, бал үзэгний болон сандал, ширээний хүртээмжийг нэмэгдүүлж, байгууллагын дотоод үзэмжид анхаарах
- Зарим үйлчилгээний цэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх боломжоор хангаж туслан дэмжих
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэдтэй, жирэмсэн эхчүүдийг дараалалгүйгээр үйлчлэх бололцоог дэмжих
- Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй цэгүүдийн (нэг цэгийн үйлчилгээнээс бусад), тэр дундаа сум, дүүрэг, хороодын гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтой болгон ижилсүүлж, жигд мэдээллээр хангах тогтолцоог бүрдүүлэх
- Үйлчилгээний цэгүүдийн гадаад болон дотоод засвар үйлчилгээг тогтмолжуулж, орчин үеийн техник хэрэгслийг үйлчилгээний танхимд нэвтрүүлэх

ХАВСРАЛТ



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА ХУУДАС

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Энэхүү судалгааг хуулийн этгээдийн улсын бүртгэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хуулийн этгээдэд үзүүлэх чанар, хүртээмжийг үнэлэх, санал зөвлөмж өгөх зорилгоор явуулж байна.

Уг судалгаанд та хамрагдсанаар улсын бүртгэлийн үйлчилгээг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй юм. Бид энэхүү судалгаагаар олж илрүүлсэн баримт мэдээллийг Монгол Улсын хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгааны үр дүнг боловсруулахад ашиглах болно.

Цаг зав гаргаж байгаа танд баярлалаа.

2024 оны 10 дугаар сар

СУДЛААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

Хэрэглэгчийн бүлэг	Хуулийн этгээдийн бүртгэл ба эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл		
Асуулгын дугаар		Байршил	
Судлаачийн дугаар		Огноо	

Та 2024 онд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үү?	① Тийм	Судалгааг үргэлжлүүлнэ.
	② Үгүй	Судалгааг үргэлжлүүлэх шаардлагагүй.

1. БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ					
1.1.	Байгууллагын байршил	① Улаанбаатар хот		② Орон нутаг	
1.2.	Өмчийн хэлбэр	① Төрийн	② Орон нутгийн		③ Хувийн
1.3.	Үндсэн ажилтнуудын тоо	① 10 хүртэл	② 11-30	③ 31-50	④ 51-70 ⑤ 71-ээс дээш
1.4.	Байгууллагын хэлбэр	① ХК, ХХК	② Хоршоо	③ Төсвийн	④ Төрийн бус

2. УБЕГ-ЫН ТАНИГДСАН БАЙДАЛ						
2.1.	Та Улсын бүртгэлийн байгууллагын талаар хэр сайн мэдэх вэ?	Мэдэхгүй ①	Бага зэрэг ②	Дунд зэрэг ③	Мэднэ ④	Маш сайн ⑤
2.2.	Та УБЕГ-ын бодлого, чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн ямар сувгаар авдаг вэ? (2-оос дээш хариулт байж болно)	① www.burtgel.gov.mn цахим хуудас ② Байгууллагын лавлах утас 1800-1890 ③ Мэдээллийн самбар			④ Брошур танилцуулга ⑤ Нийгмийн сүлжээ FB, Twitter ⑥ Сонин, сэтгүүл ⑦ Телевиз, радио, FM ⑧ Мэдээллийн сайтууд	

2.3.	Та 2024 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ямар үйлчилгээ авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	<ul style="list-style-type: none"> <li>① Хуулийн этгээд шинээр байгуулагдсан бүртгэл</li> <li>② Хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бүртгэл</li> <li>③ Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт орсон бүртгэл</li> <li>④ Хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон/атан буугдсан бүртгэл</li> <li>⑤ Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрын бүртгэл</li> <li>⑥ Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл</li> <li>⑦ Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах бүртгэл</li> <li>⑧ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаа, хуулбар өгөх</li> <li>⑨ Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй</li> </ul>
2.4.	Та 2024 онд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ямар үйлчилгээ авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	<ul style="list-style-type: none"> <li>① Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх /орон сууц, хувийн орон сууц, үйлчилгээний зориулалттай гэх мэт/</li> <li>② Төрөөс хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх</li> <li>③ Өмчлөх эрх шилжүүлэх, шилжүүлэн авах /худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ, өв залгамжлалаар, шүүхийн шийдвэрээр, хамтран өмчлөгч нэмэгдэх, хасагдах/</li> <li>④ Барьцааны гэрээний бүртгэл, гэрээ дуусгавар болгох бүртгэл</li> <li>⑤ Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах /хаяг өөрчлөгдөх, үнэ өөрчлөгдөх, хэмжээ өөрчлөгдөх, кадастрын дугаар өөрчлөгдөх, зориулалт өөрчлөгдөх гэх мэт/</li> <li>⑥ Бусад бүртгэл-түрээсийн гэрээний бүртгэл, урьдчилсан тэмдэглэл хийлгэх, хүчингүй болгох, лавлагаа, мэдээлэл авах</li> <li>⑦ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй</li> </ul>
2.5.	Та 2024 онд улсын бүртгэлийн үйлчилгээг ямар цэгээс авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	<ul style="list-style-type: none"> <li>① Улсын бүртгэгчээс</li> <li>② Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/</li> <li>③ E-Mongolia цахим портал</li> <li>④ E-Business цахим портал</li> </ul>
2.6.	УБЕГ-ын сүүлийн нэг жилийн хугацаанд хийсэн хамгийн үр дүнтэй, сэтгэлд хүрсэн үйлчилгээг нэрлэнэ үү. (2-оос дээш хариулт байж болно)	<ul style="list-style-type: none"> <li>① www.burtgel.gov.mn цахим хуудас</li> <li>② E-Mongolia цахим портал</li> <li>③ Нэг цэгийн үйлчилгээ</li> <li>④ Гэрэгэ киоск</li> <li>⑤ Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/</li> <li>⑥ Зөөврийн тоног төхөөрөмжөөр үйлчилгээ үзүүлэх</li> <li>⑦ 24/7 үйлчилгээ</li> <li>⑧ Бүртгэх хугацааг богиносгосон</li> </ul>

3. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ		① Маш муу → ⑤ Маш сайн					Мэдэхгүй
3.1.	Улсын бүртгэлийн байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд ерөнхийд нь ямар үнэлгээ өгөх вэ?	①	②	③	④	⑤	⑥
3.2.	Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийг үнэлнэ үү?	①	②	③	④	⑤	⑥
Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг үнэлнэ үү.							
3.3.	Улсын бүртгэлд шинээр бүртгэх	①	②	③	④	⑤	⑥
	Улсын бүртгэлийн өөрчлөлт	①	②	③	④	⑤	⑥
	Улсын бүртгэлээс хасалт хийх	①	②	③	④	⑤	⑥
	Тамга тэмдгийн хяналтын хуудас авах	①	②	③	④	⑤	⑥
3.4.	Үйлчилгээ авч байхад ямар нэг хүндрэл бэрхшээл гарч байсан уу?	① Тийм			② Үгүй		
3.5.	Хэрэв тийм бол ямар бэрхшээл учир байсныг дурдана уу. (2-оос дээш хариулт байж болно)	① Дараалал ихээс хугацаа алдсан					
		② Хариу хүлээж хугацаа алдсан					
		③ Бүрдүүлэх баримт бичиг хэт олон					
		④ Цахим хуудас, мэдээллийн самбарын мэдээлэл дутмаг					
		⑤ Нотариатаар гэрчлүүлэх баримт олон					

	⑥ Бөглөж өгч буй маягтын мэдээлэл их
	⑦ Хураамж, төлбөрийн хэмжээ их
	⑧ Хураамж, төлбөр төлөх процесс хүндрэлтэй
	⑨ Үйлчилгээний цагийн хуваарь богино

4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, АЖИЛТНУУДЫН ЕС ЗҮЙ							
4.1. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлнэ үү.							
		① Маш муу →			⑤ Маш сайн		Мэдэхгүй
		①	②	③	④	⑤	⑥
4.1.1.	Үйлчилгээ авахад шаардагдах хугацаа	①	②	③	④	⑤	⑥
4.1.2.	Үйлчилгээ авахад дунджаар ямар хугацаа зарцуулдаг вэ?	① Ажлын 1 хоног ② Ажлын 3 хоног			③ Ажлын 5 хоног ④ Ажлын 5 хоногоос дээш		
4.1.3.	Үйлчилгээ авахын тулд хэдэн төрлийн материал бүрдүүлдэг вэ? Тоог бичнэ үү	① 3-аас бага ③ 7-10			② 4-6 ④ 10-аас дээш		
4.1.4.	Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар	①	②	③	④	⑤	⑥
4.1.5.	Бүртгэлийн ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал	①	②	③	④	⑤	⑥
4.1.6.	Санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо	①	②	③	④	⑤	⑥
4.1.7.	Эргэх холбоо, хариу мэдээлэл	①	②	③	④	⑤	⑥
4.2. Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлнэ үү.							
4.2.1.	Үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж	①	②	③	④	⑤	⑥
4.2.2.	Үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь	①	②	③	④	⑤	⑥
4.2.3.	Маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.2.4.	Үйлчилгээ үзүүлэх, маягт, зааварчилгаа ойлгомжтой хялбар эсэх	①	②	③	④	⑤	⑥
4.2.5.	Үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал	①	②	③	④	⑤	⑥
4.2.6.	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл мэдээлэл, зөвлөгөөг авах боломжтой байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3. Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйг үнэлнэ үү							
4.3.1.	Үйлчлүүлэгчдэд туслахад бэлэн, түргэн шуурхай үйлчлэх байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3.2.	Эелдэг, таатай харилцаа	①	②	③	④	⑤	⑥
4.3.3.	Бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах	①	②	③	④	⑤	⑥
4.3.4.	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3.5.	Зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх	①	②	③	④	⑤	⑥
4.3.6.	Ажилтнуудын цаг баримтлах, цагийн зөв зохион байгуулах чадвар	①	②	③	④	⑤	⑥
4.3.7.	Шударга байх, хууль дээдлэх	①	②	③	④	⑤	⑥
4.4. Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцөлийг үнэлнэ үү							
4.4.1.	Гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал	①	②	③	④	⑤	⑥
4.4.2.	Дотоод орчны цэвэр, тав тухтай байдал	①	②	③	④	⑤	⑥
4.4.3.	Танхим, ширээ сандалны хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥

4.4.4.	Маягт бөглөхөдө шаардлагатай мээээлэл, үзэг, балны хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.4.5.	Гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал	①	②	③	④	⑤	⑥
4.4.6.	Автомашинны зогсоолын хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.4.7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх	①	②	③	④	⑤	⑥
4.4.8.	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ямар асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлээсэй гэж хүсэж байна вэ?						

**5. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын үйл ажиллагаанд өгөх судалгааны асуулгад тусгагдаагүй санал байвал бичнэ үү?**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Судалгаанд оролцсон танд баярлалаа ☺ ☺ ☺

ХЯНАСАН:

БТДШГ-ын ДАРГА



Т.ГАНТӨМӨР





**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ  
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА ХУУДАС**

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Энэхүү судалгааг иргэний улсын бүртгэл болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх чанар, хүртээмжийг үнэлэх, санал зөвлөмж өгөх зорилгоор явуулж байна.

Уг судалгаанд Та хамрагдсанаар улсын бүртгэлийн үйлчилгээг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй юм. Бид энэхүү судалгаагаар олж илрүүлсэн баримт мэдээллийг Монгол Улсын хуулийн дагуу чандлан хадгалж, зөвхөн судалгааны үр дүнг боловсруулахад ашиглах болно.

Цаг зав гаргаж байгаа танд баярлалаа.

2024 оны 10 дугаар сар

**СУДЛААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:**

<b>Хэрэглэгчийн бүлэг</b>	<b>Иргэний улсын бүртгэл ба эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл</b>		
Асуулгын дугаар		Байршил	
Судлаачийн дугаар		Огноо	

Та 2024 онд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн үү?	① <b>Тийм</b>	Судалгааг үргэлжлүүлнэ.
	② <b>Үгүй</b>	Судалгааг үргэлжлүүлэх шаардлагагүй.

<b>I. СУДАЛГААНД ОРОЛШОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ</b>						
1.1.	Нийслэл, аймаг	① Улаанбаатар хот		② Орон нутаг		
1.2.	Хүйс	① Эрэгтэй			② Эмэгтэй	
1.3.	Нас	① 30 хүртэл	② 31-40	③ 41-50	④ 51-60	⑤ 61-аас дээш
1.4.	Боловсрол	① Бага		② Бүрэн бус дунд	③ Бүрэн дунд	④ Дээд
1.5.	Ажил эрхлэлт	① Төрийн байгууллага ② Олон улсын байгууллага ③ Төрийн бус байгууллага ④ Хувийн байгууллага			⑤ Хувиараа хөдөлмөр эрхлэгч ⑥ Тэтгэвэрт ⑦ Оюутан ⑧ Эрхэлсэн ажилгүй	

2. УБЕГ-ЫН ТАНИГДСАН БАЙДАЛ						
2.1.	Та Улсын бүртгэлийн байгууллагын талаар хэр сайн мэдэх вэ?	Мэдэхгүй ①	Бага зэрэг ②	Дунд зэрэг ③	Мэднэ ④	Маш сайн ⑤
2.2.	Та УБЕГ-ын бодлого, чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ихэвчлэн ямар сувгаар авдаг вэ? (2-оос дээш хариулт байж болно)	① www.burtgel.gov.mn цахим хуудас ② Байгууллагын лавлах утас 1800-1890 ③ Мэдээллийн самбар		④ Брошур танилцуулга ⑤ Нийгмийн сүлжээ FB, Twitter ⑥ Сонин, сэтгүүл ⑦ Телевиз, радио, FM ⑧ Мэдээллийн сайтууд		
2.3.	Та 2024 онд иргэний улсын бүртгэлийн ямар үйлчилгээ авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	① Төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, нас барсны бүртгэл ② Үрчлэлт, овог нэр өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний бүртгэл ③ Иргэний үнэмлэх, гадаад паспорт ④ Лавлагаа авах ⑤ Иргэний улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй				
2.4.	Та 2024 онд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ямар үйлчилгээ авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	① Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх /Орон сууц, хувийн орон сууц, үйлчилгээний зориулалттай гэх мэт/ ② Төрөөс хувьчилсан орон сууц, газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх ③ Өмчлөх эрх шилжүүлэх, шилжүүлэн авах /худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ, өв залгамжлалаар, шүүхийн шийдвэрээр, хамтран өмчлөгч нэмэгдэх, хасагдах гэх мэт/ ④ Барьцааны гэрээний бүртгэл, гэрээ дуусгавар болгох бүртгэл ⑤ Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах /хаяг өөрчлөгдөх, үнэ өөрчлөгдөх, хэмжээ өөрчлөгдөх, кадастрын дугаар өөрчлөгдөх, зориулалт өөрчлөгдөх гэх мэт/ ⑥ Бусад бүртгэл-гүрээсийн гэрээний бүртгэл, урьдчилсан тэмдэглэл хийлгэх, хүчингүй болгох, лавлагаа, мэдээлэл авах ⑦ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс үйлчилгээ аваагүй				
2.5.	Та 2024 онд улсын бүртгэлийн үйлчилгээг ямар цэгээс авсан бэ? (2-оос дээш хариулт байж болно)	① Улсын бүртгэгчээс ② Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ ③ E-Mongolia цахим портал				
2.6.	УБЕГ-ын сүүлийн нэг жилийн хугацаанд хийсэн хамгийн үр дүнтэй, сэтгэлд хүрсэн үйлчилгээг нэрлэнэ үү. (2-оос дээш хариулт байж болно)	① www.burtgel.gov.mn цахим лавлагаа, үйлчилгээ ② E-Mongolia цахим портал ③ Нэг цэгийн үйлчилгээ ④ Гэрэгэ киоск ⑤ Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ ⑥ Харьяалал харгалзахгүй үйлчилгээ		⑦ Эрүүл мэндийн дундын мэдээллийн сан ⑧ Цахим гадаад паспорт ⑨ Зөөврийн тоногт тохөөрөмжөөр үзүүлэх үйлчилгээ ⑩ 24/7 үйлчилгээ ⑪ Бусад		

3. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ							
		① Маш муу → ⑤ Маш сайн					Мэдэхгүй
3.1.	Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд ерөнхийд нь ямар үнэлгээ өгөх вэ?	①	②	③	④	⑤	⑥
3.2.	Улсын бүртгэлийн байгууллагын өнгө төрх, имиджийг үнэлнэ үү?	①	②	③	④	⑤	⑥
Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг үнэлнэ үү.							
Улсын бүртгэлд шинээр бүртгэх		①	②	③	④	⑤	⑥
3.3.	Улсын бүртгэлийн өөрчлөлт	①	②	③	④	⑤	⑥
Улсын бүртгэлээс хасалт хийх		①	②	③	④	⑤	⑥
Лавлагаа, тодорхойлолт авах		①	②	③	④	⑤	⑥
3.4.	Үйлчилгээ авч байхад ямар нэг хүндрэл бэрхшээл гарч байсан уу?	① Тийм			② Үгүй		

3.5.	Хэрэв тийм бол ямар бэрхшээл учир байсныг дурдана уу. (2-оос дээш хариулт байж болно)	① Дараалал ихээс хугацаа алдсан
		② Хариу хүлээж хугацаа алдсан
		③ Бүрдүүлэх баримт бичиг хэт олон
		④ Цахим хуудас, мэдээллийн самбарын мэдээлэл дутмаг
		⑤ Нотариатаар гэрчлүүлэх баримт олон
		⑥ Бөглөж өгч буй маягтын мэдээлэл их
		⑦ Хураамж, төлбөрийн хэмжээ их
		⑧ Хураамж, төлбөр төлөх процесс хүндрэлтэй
		⑨ Үйлчилгээний цагийн хуваарь

4. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, АЖИЛТНУУДЫН ЕС ЗҮЙ							
4.1.	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлнэ үү.	① Маш муу → ⑤ Маш сайн					Мэдэхгүй
		①	②	③	④	⑤	
4.1.1.	Үйлчилгээ авахад шаардагдах хугацаа	①	②	③	④	⑤	⑥
4.1.2.	Үйлчилгээ авахад дунджаар ямар хугацаа зарцуулаг вэ?	① Ажлын 1 хоног			③ Ажлын 5 хоног		
		② Ажлын 3 хоног			④ Ажлын 5 хоногоос дээш		
4.1.3.	Үйлчилгээ авахын тулд хэдэн төрлийн материал бүрдүүлдэг вэ? Тоог бичнэ үү	① 3-аас бага			② 4-6		
		③ 7-10			④ 10-аас дээш		
4.1.4.	Ажилтнуудын мэдлэг, мэргэжлийн болон зөвлөгөө өгөх чадвар	①	②	③	④	⑤	⑥
4.1.5.	Бүртгэлийн ажилтнууд нь нэг удаагийн хандалтаар асуудлыг шийдэж өгөхийг хичээдэг байдал	①	②	③	④	⑤	⑥
4.1.6.	Санал, хүсэлт, гомдол хүлээн авах тогтолцоо	①	②	③	④	⑤	⑥
4.1.7.	Эргэх холбоо, хариу мэдээлэл	①	②	③	④	⑤	⑥
4.2.	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг үнэлнэ үү.						
4.2.1.	Үйлчилгээний ачаалал, үйлчилгээ үзүүлж буй ажилтны хүртээмж	①	②	③	④	⑤	⑥
4.2.2.	Үйлчилгээ үзүүлж буй цагийн хуваарь	①	②	③	④	⑤	⑥
4.2.3.	Маягт, зааварчилгаа зэргийн хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.2.4.	Үйлчилгээ үзүүлэх, маягт, зааварчилгаа ойлгомжтой хялбар эсэх	①	②	③	④	⑤	⑥
4.2.5.	Үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал	①	②	③	④	⑤	⑥
4.2.6.	Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл мэдээлэл, зөвлөгөөг авах боломжтой байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3.	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны харилцааны соёл, ёс зүйг үнэлнэ үү						
4.3.1.	Үйлчлүүлэгчдэд туслахад бэлэн, түргэн шуурхай үйлчлэх байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3.2.	Эелдэг, таатай харилцаа	①	②	③	④	⑤	⑥
4.3.3.	Бүх үйлчлүүлэгчтэй ижил, тэгш харилцах	①	②	③	④	⑤	⑥
4.3.4.	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	①	②	③	④	⑤	⑥
4.3.5.	Зөвлөгөө өгч, чирэгдэлгүй үйлчлэх	①	②	③	④	⑤	⑥
4.3.6.	Ажилтнуудын цаг баримтлах, цагийн зөв зохион байгуулах чадвар	①	②	③	④	⑤	⑥
4.3.7.	Шударга байх, хууль дээдлэх	①	②	③	④	⑤	⑥
4.4.	Улсын бүртгэлийн байгууллагын орчин нөхцөлийг үнэлнэ үү						
4.4.1.	Гадна болон дотоод хаяг, тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц, ойлгомжтой байдал	①	②	③	④	⑤	⑥
4.4.2.	Дотоод орчны цэвэр, тав тухтай байдал	①	②	③	④	⑤	⑥

4.4.3.	Танхим, ширээ сандалны хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.4.4.	Маягт бөглөхдөө шаардлагатай мэдээлэл, үзэг, балны хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.4.5.	Гадаад орчны цэвэр, хүрэлцээтэй байдал	①	②	③	④	⑤	⑥
4.4.6.	Автомашинны зогсоолын хүрэлцээ	①	②	③	④	⑤	⑥
4.4.7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх	①	②	③	④	⑤	⑥
4.4.8.	Улсын бүртгэлийн ерөнхий газраас ямар асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлээсэй гэж хүсэж байна вэ?						

**5. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын үйл ажиллагаанд өгөх судалгааны асуулгад тусгагдаагүй санал байвал бичнэ үү?**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Судалгаанд оролцсон танд баярлалаа 😊😊😊

ХЯНАСАН:

БТДШГ-ын ДАРГА



Т.ГАНТӨМӨР